Эрүүгийн хуулийг амилуулах хууль батлагдлаа

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь өмнөх хуулиас 40 орчим хувиар өөрчлөгдсөн. > 2

“Lingua franca- 1”

Англи хэл өргөн хэрэглэх болсон нь дэлхийг Англо-Америкийн иргэншилд хэт хамаатуулсных. > 4

Хэмнэлтээс “төрсөн” бизнесийн санаа

Кофены шаар нь органик бүтээгдэхүүний шилдэг орц болдог. > 6

20 жил MobiCom | MobiCom

NNC NATIONAL NEWS CORP | БҮРЭЛДЭХҮҮН КОМПАНИ

ubinfo.mn

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.05.19, БААСАН ~ №094 (640)

ҮНЭ: 600₮

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах саналаа хүргүүллээ.

Шивээ-Овоогийн ордыг түшиглэн цахилгаан станц барих хүсэлтээ илэрхийлэв.

УИХ-аас Залуучуудын хөгжлийн тухай хуулийг баталлаа.

Архивын ерөнхий газрын даргаар түүхч Д.Хоролдамбыг томилжээ.

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын чуулган өнөөдөр өндөрлөнө.

ЭДИЙН ЗАСАГ

Төв банкны цахим хуудсанд валют арилжааны цахим талбарын ханшийг зарладаг боллоо.

Монголын хөрөнгийн биржийн индекс 845.46 нэгж болж, 0.05 хувиар өсөв.

Хөвсгөл аймгийн хэмжээнд ашиглалтын 18 лиценз хүчинтэй байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 3.7 их наяд төгрөгт хүрэв.

БНХАУ санхүүгийн зах зээл дэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч эхэллээ.

НИЙГЭМ

Хуурайшилт ихсэж, нэн аюултай зэрэглэлд хүрээд байгааг ОБЕГ-аас анхааруулав.

Их аварга Д.Дагвадорж Ж.Дамдинсүрэнгийн зээнцэрт байр бэлэглэхээр боллоо.

Дотоодын 50 гаруй аж ахуйн нэгж төгсөгчдөд 1200 ажлын байр санал болгов.

СХД-ийн 10 дугаар хороол-лын туслах замд автомашины зогсоол байгуулна.

Нийслэлийн ИТХ-ын ээлжит хурлаар 2017 оны төсвийн нэмэлт, өөрчлөлтийг батлав.

ДЭЛХИЙ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сон-гуульд ОХУ хутгалдсан, эсэхийг FBI экс удирдлага тогтооно.

Иранчууд дараагийн Ерөнхийлөгчөө өнөөдөр сонгоно.

Дубай 2020 онд 1.7 тэрбум ам.долларын хөрөнгөөр, хүний гараар арал байгуулна гэв.

Австралийн татварын ажилтан албан тушаалаа урвуулж, мөнгө завшсан хэрэгт холбогдов.

Турк Сирийн дүрвэгсдэд зориулан хоёр жилийн хугацаанд хотхон байгуулна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.05.19

17° | 12°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 00640

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Бизнес өсөлтийн мөчлөгт шилжлээ

Бизнесийн итгэлийн индекс тасралтгүй өссөн хэвээр байгааг “World Economics” онцолж байна. Энэ нь ашиг, орлого гэдгийг бараг л мартчихсан яваа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа ялимгүй сэргэж байгааг илтгэв. ▶3

С.Батсайхан / ЗГМ©

FT Бээжингээс Пакистанд хэрэгжүүлж буй “Зууны төслүүд”

Хэнни Сэндер, Кайрен Стэйси

Лахор хотын Pearl Continental зочид буудлын үүдний танхимд байрлуулсан уриа нэлээдгүй хөөргөн. CPEC буюу БНХАУ, Пакистаны эдийн засгийн коридорыг сурталчлан “Пакистан-Хятадын найрамдал мандтугай” гэсэн үг бичжээ. Мөн “Бидний нөхөрлөл Хималайн нуруунаас өндөр, дэлхийн хамгийн гүн далайгаас ч гүн, зөгийн балнаас ч амттай” гэсэн бичээс харагдана.

Энэхүү гүн, гүнзгий, амтлаг нөхөрлөл их мөнгөний үнэ цэнэтэй. Өрнөд Хятадыг Пакистанаар дамжуулан Арабын тэнгист гаргах CPEC схем нь илүү амбийцлаг “Нэг бүс-нэг зам” төслийн бүрдэлд багтдаг. Дэлхийн хоёр дахь гол эдийн засгийг төв Ази, Европ, Африктай холбох орчин цагийн Торгоны зам үүсгэх “Нэг бүс-нэг зам” санаачилгад дэлхийн 65 улс хамаарч байгаа. Уг санаачилга нь БНХАУ-ын дарга Ши Жиньпиний хайртай төсөл. Дэд бүтцэд тулгуурлаж буй уг төслийн явцыг бусад улсын удирдагчдад энэ долоо хоногт тайлбарлах үеэрээ ноён Ши “зууны төсөл” гэсэн үг хэрэглэж байлаа.

Өнгөн талдаа ноён Шигийн төсөл хамгийн өгөөжтэй тусах улс нь Пакистан гарцаагүй мөн. Тус улсын эдийн засгийн өсөлт жилдээ бараг таван хувьтай байгаа нь тун ч дажгүй үзүүлэлт. Гэвч энэхүү өсөлт нь хөдөлмөрийн зах зээлд жил бүр 2-3 саяар нэмэгдэж буй хүмүүсийг шингээж дийлэхгүй байна.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК

ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА

(2017 оны I улиралд, төгрөгөөр)



Үндэсний статистикийн хороо©

ЗГМ: СЭДЭВ

Хүнсэнд нуугдсан хортой тоглоомууд

Жилд 35000 хүүхэд химийн хорт бодисын нөлөөллөөр амь насаа алддаг

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Эцэг, эхчүүд хүүхдэдээ аль болох чихэр, жимс бага авч өгөхийг боддог. Гэвч ээж, аавыгаа даган дэлгүүр орсон жаалууд харснаа авч байж санаа нь амардаг. Тэд ихэвчлэн эрээвэр хураавар бичигтэй, элдэв төрлийн тоглоомтой чихэр, жимсийг илүүд үзнэ. Тэгвэл хүүхдийнхээ сонгосон бүтээгдэхүүнийг үг дуугүй авч өгөхөөсөө өмнө та эрүүл ахуй, чанар стандартын шаардлага хангасан, эсэх талаар бодож үзэж байв уу. Учир нь хүнсний бүтээгдэхүүнтэй хамт савласан тоглоомоос ялгарах хор таны хүүхдийн ходоодонд хүнсээр дамжин орж, эрүүл мэндэд нь заналхийлж байна.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зах зээлд борлуулж буй нийтлэг 62 хуванцар тоглоомыг сонгон судалгаа, шинжилгээ хийжээ. Ингэхэд 98 хувь нь урд хөршид үйлдвэрлэсэн тоглоом байсан аж. Хамгийн ноцтой нь тэдгээр тоглоомын 26 хувиас нь хром, хар тугалга, кадьми, хөнгөн цагаан, цайр зэрэг химийн бодис илэрчээ. Тодруулбал, хромын агууламж 50 хувьд нь, хар тугалга 25 хувьд нь зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарсан байна.

▶5

ЭДИЙН ЗАСАГ

Эрүүлжиж эхэлсэн улсын төсөв

Г.Байгал
@baigalZGM

Долларын богцтой зээлийн багц олон хүнд найдвар төрүүлээд байна. Албан мэдээллээр ОУВС-гийн Захирлуудын зөвлөл энэ сарын 24-нд Монголын хүсэлтийг хэлэлцэх аж. Хэрэв хэлэлцээр урагшилбал нийт 4.4 тэрбум ам.долларын мөнгөн урсгал Монголыг чиглэнэ. “Цус”-ны эргэлтгүй болсон Монголын эдийн засагт энэ мөнгө амь тариа ч болж мэднэ. Сангийн сайдын мэдэгдсэнээр хамтарсан хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дийлэнхийг төсвийн алдагдал нөхөхөд зарцуулах аж. Ингэснээр өдөр өдрөөр өсөж буй төсвийн алдагдал буурч, дундарч буй төрийн сан дүүрэх нь. Тэгвэл олон улсын тусламж, дэмжлэгээс өмнө одоогийн төсвийн нөхцөл байдал ямар байгааг тандъя. Төрийн “хэтэвч” рүү өнгийвөл энэ онд төсвийн орлого өсөж, зарлага жилийн өмнөхөөс буурсан үзүүлэлттэй байна.

▶11

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
845.45	1260.97	5610	96.830	100.02	2418.32	350.83	42.02
0.05%	0.03%	0.02%	0.17%	0.04%			

Улс төр

ЕРӨНХИЙЛӨГЧ

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах саналаа хүргүүлэв

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй танилцаж, саналаа хүргүүлжээ.

Тэрбээр Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, уг хуулийг дээдлэх ёсыг хангах үүднээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ, Засгийн газрын хоорондын эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцвэрийн зарчмын хүрээнд хязгаарлах нь зүйтэй хэмээн үзжээ. Тодруулбал, Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүнийг томилох, энэхүү шийдвэрийг Ерөнхийлөгч 72 цагийн дотор батламжлах, шинээр Ерөнхий сайд томилогдсоноор өмнөх Ерөнхий сайдыг огцруулах шийдвэр хүчин төгөлдөр болох болон УИХ-ын ээлжит бус сонгуулийг зарлах тухай Ерөнхий сайд саналаа өргөн мэдүүлбэл Ерөнхийлөгч 72 цагийн дотор батламжлах ёстой хэмээн үзсэн байна.

Мөн Засгийн газрын гишүүн УИХ-ын гишүүний ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй байх ёстойг ч дурджээ. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүн "давхар дээл"-тэй байхыг эсэргүүцсэн байна. Үүнээс гадна Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах шийдвэр гаргасан бол энэ тухай УИХ, Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэх ёстой хэмээн үзжээ. [ЗГМ]

УЛСЫН ИХ ХУРАЛ

Эрүүгийн хуулийг амилуулах хууль батлагдлаа

Б.Ганбаяр / ЗГМ©

Долдугаар сарын 1-нээс Эрүүгийн хууль хэрэгжих боломж бүрдлээ

Б.Даваатогтох
@datoZGM

Өнгөрсөн парламентад Эрүүгийн болон Зөрчлийн хуулийг батлалсан. Гэвч уг парламент бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоосоо өмнө дээрх хуулиудын эцсийн найруулгыг нь сонсож чадаагүй юм. Ингэснээр шинээр байгуулагдсан Засгийн газар дээрх хуулиудын хэрэгжих хугацааг хойшлуулж, хуульд засвар оруулж, өнгөрсөн долоо хоногт УИХ-аас батлалсан билээ.

Тэгвэл пүрэв гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн хуулийг амилуулах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталлаа. Ингэснээр ирэх долдугаар сарын 1-нээс Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэх боломж бүрдэж байгаа юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд гэмт хэрэгтэн, сэжигтэн, яллагдагч, хохирогч нарт Эрүүгийн хууль ямар байдлаар үйлчлэх вэ гэдгийг тодорхой заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах үүднээс баримт бичгийг танилцуулах, хүргүүлэхэд баримтлах журмыг тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг шүүх, прокурорт дуудан ирүүлэх ажиллагааг хэрхэн явуулах талаар нарийвчлан заасан. Мөрдөгч гэрч, хохирогч, шинжээч, яллагдагчаас мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулах зайлшгүй шаардлагатай бол прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэхээр, мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол шүүх өөрийн санаачилгаар, эсвэл прокурорын хүсэлтийн дагуу албадан ирүүлэх тухай шийдвэр гаргахаар заажээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь өмнөх хуулиас 40 орчим хувиар өөрчлөгдсөн бөгөөд ял шийтгэлийн бодлогын хувьд зөөлөрсөн гэж хэлж болно. Тодруулбал, хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах чиглэлд анхаарч гэрийн хорионд байлгах ял, тэнсэх албадлагын арга хэмжээ, гэм буруугаа хүлээсэн хүнд ногдуулах эрүүгийн хариуцлага, өсвөр насны хүнд ногдуулах ял гэсэн шинэлэг заалтыг оруулсан байна.

Эрүүгийн хууль нь өмнөх хуулиас 40 орчим хувиар өөрчлөгдсөн

Ингэснээр хорих ял биечлэн эдлэх явдлыг 20-30 хүртэл хувиар бууруулахын зэрэгцээ ялын үр нөлөө дээшилнэ гэж үзэж байгаа юм. Мөн одоо ял эдлэж буй 6000 орчим ялтны ял хөнгөрч, цаашлаад зарим нь хугацаанаасаа өмнө суллагдах хууль эрхзүйн орчин бүрдэж байгааг албаны хүмүүс онцолж буй. Үүнээс гадна хуульд албадан ажил хийлгэх хугацаа нь 120-480 цаг, гэрийн хорионд байлгах хугацааг 1-5 жил хүртэл байхаар тусгасан. Мөн гэмт хэрэг хүлээлгэх насны хязгаарын хувьд 16 наснаас эхлэх, харин тодорхой гэмт хэргийн тухайд 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгажээ.

Түүнчлэн авлигын гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалт тусгасан. Тодруулбал, авлига өгөх гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд заавал эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг нэмсэн байна. [ЗГМ]

ЭШЛЭЛ

-Төрийн албан хаагчийг хариуцлагажуулах чиглэлээр олон заалт орсон. Төрийн удирдах албан тушаалтан буюу шийдвэр гаргадаг хүмүүсийг хариуцлагатай болгох ёстой. Хэрэв буруу шийдвэр гаргасан бол санхүүгийн хохирлыг нь хувиасаа төлнө. Энэ бол төрийн албыг хариуцлагажуулах том заалт. Мөн төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг хуульд шинээр тусгаж өгсөн. Дүгнэх, хариуцлага тооцох, урамшуулахыг бүгдийг заасан. Үүнээс гадна төрийн үйлчилгээний чанар хүртээмжид үнэлэлт, дүгнэлт өгдөг орон тооны бус Олон нийтийн зөвлөл бий болгож байгаа юм. Засгийн газраас гишүүн байхгүй, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн есөн хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байна. Жил бүр төрийн байгууллагуудад аудит хийлгэж, төрийн үйлчилгээнд үнэлгээ өгөх юм. Мөн Төрийн захиргааны албан хаагчдад хэрэглэгчдээр буюу иргэдээр үнэлгээ өгүүлдэг систем бий болгож байгаа юм.

УИХ-ын гишүүн
Д.Тогтохсүрэн

-Сонгуулийн тухай хуульд зааснаар хилийн чанадад байгаа иргэд санал авах өдрөөс 40 хоногийн өмнөөс эхлэн 20 хоногийн хугацаанд өөрийн оршин суугаа улсад байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт хандан бүртгүүлэх ёстой. Энэхүү заалтын дагуу сонгогчдын бүртгэлийн хугацаа энэ сарын 20-нд дуусна. 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөхөөр хилийн чанадад амьдарч байгаа 6000 гаруй иргэн бүртгүүлж, 4000 гаруй нь саналаа өгч, сонгох эрхээ эдэлсэн байдаг. Энэ удаа илүү олон хүн сонгох эрхдээ анхаарч, хариуцлагатай хандаасай гэж хүсэж байна. Тиймээс ч сонгуулийн санал авах өдөр, бүртгэлийн хугацаа, бүртгүүлэх арга хэлбэр зэрэг холбогдох мэдээллийг бүх ДТГ-ууд өөрийн цахим хуудас болон нийтлэг ашиглагддаг мэдээллийн сүлжээгээр түгээж байна. Төв комиссоос салбар комисстой байнга холбогдож өдөр тутмын үйл ажиллагааг удирдамж, чиглэлээр хангаж байгаа.

ГХЯ-ны ТНБД
Д.Даваасүрэн

ЗАСГИЙН ГАЗАР

Монголд хөрөнгө оруулалт хийх хүсэлт тавив

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат ИБУИНВУ-аас манай оронд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кэтрин Арнолд, Британийн "Ай Эм Пауэр" компанийн ерөнхий захирал Гордон Дики тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Энэ үеэр "Ай Эм Пауэр" компани Шивээ-Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэн 1.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт бүхий Цахилгаан станц барих хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. Төсөл хэрэгжсэнээр өмнө болон зүүн бүсийг найдвартай эрчим хүчээр хангах, орон нутагт ажлын байр бий болох зэрэг эерэг өөрчлөлт гарна гэж тооцоолсон байна.

Ерөнхий сайд Ажлын хэсэг байгуулж, цахилгаан станц барих асуудлыг судалж танилцуулахыг Эрчим хүчний сайд П.Ганхүүд үүрэг болгов. Хэрэв энэ төсөл хэрэгжвэл Монгол Улсын эдийн засагт үр өгөөжтэй байхаас гадна гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно хэмээн найдаж байгаагаа Ерөнхий сайд онцоллоо. [ЗГМ]

Дэд бүтцийн итгэлийн сан бий болгохыг чухалчиллаа

Тайландын нийслэл Бангкок хотноо болж буй НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 73 дугаар чуулган өнөөдөр өндөрлөнө. Уг чуулганд Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил тэргүүтэй төлөөлөгчид оролцож байгаа бөгөөд "Ази, Номхон далайн бүсийн нэн буурай хөгжилтэй, далайд гарцгүй болон арлын хөгжиж буй жижиг орнуудын дэд бүтэц ба тогтвортой хөгжил" сэдэвт өндөр түвшний хэлэлцүүлэгт үндсэн илтгэгчээр оролцов. Тэрбээр далайд гарцгүй байдал нь манай улсын хувьд сорилт болохыг тэмдэглээд худалдааны тарифын болон тарифын бус хориг саад, тээвэрлэлтийн өндөр зардлаас үүдэлтэй бэрхшээл нь манай бизнес эрхлэгчдэд тулгардаг гол асуудал болохыг тодотгов. Мөн Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр, транзит тээврийн зохицуулалт зэрэг дэд бүтцийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцууллаа.

Энэхүү хэлэлцүүлгээр бүс нутгийн тусгай хэрэгцээ шаардлагатай улс орнуудын дэд бүтцийн салбарын ололт амжилт, бэрхшээл сорилт, дэд бүтцийг дэмжих боломж, санхүүжилтийг шийдвэрлэх арга зам зэрэг асуудлыг хэлэлцжээ.

Мөн төлөөлөгчид бүс нутгийн хөгжилд дэд бүтцийн зөв төлөвлөлт, зохистой санхүүжилт шаардлагатай байгааг онцлоод, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, зохицуулалтын механизмыг сайжруулах, хувийн хэвшлийн санхүүжилтийг татах, хамтарсан санхүүжилт хийх, дэд бүтцийн итгэлийн сан бий болгохыг чухалчлав. [ЗГМ]

ТОВЧХОН

» ПАРЛАМЕНТ
УИХ-аас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачилж өргөн мэдүүлсэн Залуучуудын хөгжлийн тухай хуулийг баталлаа. Энэхүү хууль нь 15-34 насны залуучуудын нийгмийн хөгжилд оролцох оролцоог тодорхойлж, төрөөс залуучуудад дэмжлэг үзүүлэх болон эдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилготой юм.

» ТОМИЛГОО
Засгийн газрын хуралдаанаар Архивын ерөнхий газрын даргаар Д.Хоролдамбыг томилжээ. Д.Хоролдамба нь түүхийн ухааны доктор, ШУА-ийн шагналт, түүхч, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажилтан, Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, "Хархорум" нийгэмлэгийн тэргүүн зэрэг ажлыг хийж байжээ.

» ДЭД ХОРОО
УИХ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо хуралдаж, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын хэрэгжилт, биелэлт болон цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцлээ. Дээрх үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд холбогдох яам, агентлагийн мэргэжлийн хүмүүсийн оролцоо болон мэдээ, мэдээлэл зайлшгүй хэрэгтэй байгааг Ажлын хэсгээс онцлов.

» ТОО

81

Хувь. Улсад бүртгэлтэй 126560 аж ахуйн нэгжээс 64301 нь үйл ажиллагаа явуулж байгаа аж. Үүний 81 хувь нь буюу 51917 аж ахуйн нэгж буй жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч байгааг УИХ-ын Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны тайланд онцолжээ. Энэ салбарт 719172 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 67 хувийг эзэлж байгаа аж.

» ХӨТӨЛБӨР
Засгийн газраас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг баталлаа.

» АТГ
АТГ өнгөрсөн долоо хоногт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 270 мэдүүлгийг хянан шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 220 нь зөрчилгүй байсан бол 25-ыг нь буцааж, 25-д нь анхааруулсан байна.

» ШААРДЛАГА
УИХ-ын гишүүн С.Жавхлан өнгөрсөн сард УИХ-ын даргад шаардлага хүргүүлжээ. Уг шаардлагад хилийн чанадад данстай гишүүдийнхээ нэрсийг ил тод зарлаж, хариуцлага тооцох ёстойг дурджээ. Шаардлагын хариуг ирүүлээгүй тул дахин хүргүүлэхээр болсон байна. Уг шаардлагаа Ардчилсан нам болон МАХН-ын удирдлагуудад хүргүүлэх аж.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Бизнес өсөлтийн мөчлөгт шилжлээ

Худалдааны салбарын борлуулалт өссөн нь бизнест эерэг дохио

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM



С.Батсайхан / ЗГМ©

Чихэнд чимэгтэй, нааштай мэдээ дуулгая. Ийм мэдээ сонсолгүй их удсан байна. Бизнесийн орчинд хуралдаад байсан хар үүл замхарч, энэ орон зайг дүүргэх гэгээ татаж эхэллээ. Ашиг, орлого гэдгийг бараг л мартчихсан явсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа ялимгүй сэргэж байна. Тодруулбал, энэ оны эхний улиралд эдийн засаг 4.2 хувиар өссөн нь үүнийг илүү тодотгож өглөө. Алдагдал хүлээж, өр зээлийн шахаанд орсон хувийн хэвшлийнхний нуруу тэнийх цаг дөхсөөр. Төгрөгтэй харьцах ам.долларын ханш тогтворжиж, төлбөрийн тэнцлийн өндөр алдагдал хумигдав. Эдийн засгийн уналт зогсож, өсөлтийн мөчлөгт аажмаар шилжлээ. Энэ буухиатай хамт өөдрөг үзүүлэлтүүд сонор мялааж байна.

Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны 2017 оны таамгийг дээрх эрчээрээ манай улсын эдийн засаг эвдэж мэдэхээр байна. Оны хоёр болон гуравдугаар улиралд бүтээн байгуулалт идэвхжиж, их ажлын нүргээн дунд барилга, уул уурхай, дэд бүтэц, хот байгуулалтын салбарынхан илүү завгүй байдаг үе ирлээ. Гадаад валютын ханшийн дарамтад ороод байсан дотоодын компаниуд амьсгаа авч, борлуулалтын орлого нь өсөлтийн зүг заав.

Ажилтнаа цомхотгож, үйл ажиллагааны зардлаа танаад байсан аж ахуйн нэгжүүд ирээдүйгээ илүү өөдрөгөөр харж, ажлын зар түгээх боллоо. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа сэргэх хэрээр ажилтай, орлоготой монгол хүний тоо нэмэгдэнэ гэсэн үг. Өрхийн орлого өсөх тусам бараа, бүтээгдэхүүний борлуулалт сайжирч, эдийн засаг дахь мөнгөний эргэлт эрчимжинэ. Ингэснээр хөрөнгө оруулалт нь саатчихсан төслүүд амилж, тэнд ажлын байр шинээр бий болж, ядуурлыг үүсгэж буй ажилгүйдлийн түвшин аажмаар буурна. Энэ зүй тогтлоор эдийн засаг тамир суух учиртай.

Худалдааны салбарын нийт борлуулалт энэ оны эхний улиралд 2.7 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.4 хувиар нэмэгдсэн. Энэ нь хямралын сүүдэр холдож байгааг илтгэнэ. Баялаг бүтээгчид ч үүнийг чамласангүй. Он дамнан үргэлжилсэн хүндрэлийн шарх ийнхүү илааршиж, бизнесийн орчинд өөдрөг тоон үзүүлэлтүүд ажиглагдах болов. Агшиж байсан худалдааны салбарын борлуулалт зөвхөн нэг улиралд 606.9 тэрбум төгрөгөөр өссөн нь бизнест эерэг дохио болж байна. Борлуулалт сэргэсэн нь иргэдийн худалдан авах чадварт ахиц гарч байгаагийн илрэл юм. Бараа, бүтээгдэхүүн худалдан авах хүмүүсийн эрэлт, хэрэгцээ өмнө нь буурч байсан бол одоо эсрэгээрээ нэмэгдэж байгааг дуулгахад үнэхээр таатай байна. Дефляцийн аюул нэг мөр холдож, инфляцийн хэвийн өсөлт эдийн засагт тогтох нь.

Дефляцийн үзэгдэл нь бараа үйлчилгээг худалдан авах хүмүүсийн эрэлт, хэрэгцээ буурснаар үйлдвэрлэгч компаниуд өөрсдийн бүтээгдэхүүнээ хямд үнээр борлуулж, үүнээсээ алдагдал хүлээхэд хүргэдэг үр дагавартай. Үүнийг бизнес эрхлэгчид даваад гарч байна. Улсын хэмжээнд 73.3 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэйг Үндэсний статистикийн хорооноос танилцуулсан юм. Үүдээ барьсан аж ахуйн нэгжүүдээс үлдсэн нь 73.3 мянгаар хэмжигдэж байна. Тэдний гуравны нэг буюу 28.1 мянга нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд.

Эдийн засгийн хүндрэлийг хамгийн ихээр мэдэрсэн хэсэг бол бөөний болон жижиглэн худалдааны салбарынхан. Энэ салбарын үзүүлэлт нэгдүгээр улиралд өндийж, богино хугацаанд сэргэлт авлаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад жижиглэн худалдааны борлуулалт 282.9 тэрбум төгрөгөөр өссөн бол бөөний худалдааных 324 тэрбум төгрөг болж, алдагдлаа бага зэрэг нөхлөө. Худалдааны салбарын борлуулалтын 90 гаруй хувь нь нийслэлд ногдож байгаа. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 60 орчим хувь нь төвлөрч буй хот, суурин газарт бизнесийн үйл ажиллагаа илүү идэвхжиж байна.

"World Economics" байгуулламгаас гаргасан манай улсын борлуулалтын менежерүүдийн индекс тавдугаар сард сэргэлтийн бүс рүү орсон талаар мэдээллээ. Индексийн голлох үзүүлэлт болох зах зээлийн өсөлтийн индекс сүүлийн гурван жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Бизнесийн итгэлийн индекс тасралтгүй өссөн хэвээр байгааг "World Economics" онцоллоо. Борлуулалтын менежерүүдийн индексийг дотоодын нийт бүтээгдэхүүний 30-аас доошгүй хувийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг томоохон компаниудын худалдааны менежерүүдээс авсан судалгаан дээр үндэслэн гаргадаг. Индексийн үзүүлэлт 50 нэгжээс дээш байвал эдийн засаг тэлж байгаагийн шинж.

Итгэл алдарсан хөрөнгө оруулагчид Монголд дахин боломж олгохоор шийджээ. Тухайлбал, уул уурхайн төслүүд бизнесийн орчны эерэг хандлагыг мэдэрч эхэлсэн байна. Аж ахуйн нэгжүүд тасралтгүй хумигдаж байсан ашиг орлогоос үүдэн хөрөнгө оруулалтаа танасан. Тэгвэл энэ үе ард хоцрох нөхцөл бүрдэж буй юм. Хувийн хэвшил Монголын эдийн засгийн 80, ажлын байрны 75 хувийг бүрдүүлдэг. Энэ утгаараа дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, уналтыг тодорхойлох нь бий. Бизнесийн үйл ажиллагаа жигдэрч, сэргэнэ гэдэг та бидний ажлын байр баталгаажиж, өрхийн орлого нэмэгдэх эхлэл. Тэрчлэн элгээрээ мөлхсөн эдийн засагт гэгээтэй тоонууд тодрох тусам хүндрэл, хямрал сургамж болж үлдэнэ гэсэн үг. Монгол Улс бизнест эргэн ирлээ. [ЗГМ]

» Ашиг, орлого гэдгийг бараг л мартчихсан явсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа ялимгүй сэргэж байна.

» Алдагдал хүлээж, өр зээлийн шахаанд орсон хувийн хэвшлийн нуруу тэнийх цаг дөхсөөр.

» Худалдааны салбарын нийт борлуулалт энэ оны эхний улиралд 2.7 их наяд төгрөгт хүрэв.

» Индексийн голлох үзүүлэлт болох зах зээлийн өсөлтийн индекс сүүлийн гурван жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА

Судлаачийн үг

“Lingua franca- 1”

Олхонуд Баярхүү
проф.

Геополитикийн чухал зэвсэг нь хэл болох тухай

Монголчууд төдийлэн анзаардаггүй, сонирхдоггүй ч хариулт хайж байгаа нийтлэг нэгэн асуултад хариулахаар зориглов. Би олон жил их сургуульд багшилсан болохоор эцэг эхчүүд багш, тэнхим, сургуулийн захиргааг байнга зовоож байдаг нэгэн асуудлыг сайн мэднэ. Одоо ч яг тийм байгаа. Охид, хөвгүүдээ ямар нэг гадаад хэлний анги руу өгөх, анги солиулахаар мөн ч их хөнөглөдөг дөө. Заавал “англи хэл” гэж дайраад байхыг нь яана гээч. Гадаад хэлний ийм, тийм сургалттай сургуульд элсэлт авна гэх зар эх толгойгоо алддаг, намар цагт. Сургахыг ч үзүүлж өгдөг биз.

Эх хэлээ хамгаалъя гэсэн уриатай, зарим нь гадаад хэл заалгахгүй гэсэн лоозонтой монгол хэлний эрдэмтэд боож үхэх шахна. МУИС, МУБИС-ийн нэр бүхий хэдэн ахмад багш хэвлэлийн бага хурал зарласаар байгаад, сүүлдээ сэтгүүлчдийн элэг доог болчихсон. Тэднийг тоож байгаа амьтан гэж бараг үгүй. Хөөрхий тэд насаараа монгол хэлээ олон талаас нь мөлжиж заасан, мөлжсөн тоолонгоороо ном бүтээл гаргасан, дэд доктор, докторын зэрэг хамгаалсан, гавьяат цолуудыг хүртсэн, одоо ардын цолоо түрүүчээсээ авч эхэлсэн. Түүнийг нь би гүнээ ойлгож байвч Та нарын тэмцэл, цохрол, ухуулгын цаана даян дэлхийд “хэлний геополитик” гэж нэг айхтар бодлого байдаг юм шүү, тийм тоглолт их гүрнүүдийн өвөр хооронд явагддаг юм шүү гэдгийг бэлтгэх энгийн хэдхэн баримтыг энд хүүрнэх гэж байна.

“Дэлхийн хэл бол англи хэл мөн” гэж “Wall Street Journal” сэтгүүлд бичсэн дээ. Энэ үнэн үү? Монголын залуу үе яагаад англи хэл рүү ингэтлээ үхэлдэн улайрна вэ? Үүнийг дэлхийн хүн амын дотор англи хэлээр ярилцагчдын хувь хэмжээ өсч байгаа гэдгээр өлхөн тайлбарлачихна. Гэвч шууд батлах боломжгүй. 1958-1992 оныг хамрах 30 гаруй жилийн түүхээс үзэхэд, хэлний хэрэглээний хувьд харин ч англи, франц, герман, орос, япон хэлээр ярьдаг хүний тоо цөөрч, хятадын мандарин хэлээр яригсдын тоо багахан буурсан. Харин хинди, малай-индонез, араб, бенгал, испани, португал болон бусад хэлээр яригсдын нийт дэлхийн хүн амд эзлэх хувь өссөн зураг харагдаж байна. Энэ бол хүмүүс шинээр тэдгээр хэлийг сурч судалсандаа биш хүн ам нь өссөнөөс аяндаа гарсан үр дүн юм.

Англи хэлний тухайд, наад зах нь сая хүн ярьдаг хэлний бүлэгт хамаарах хүмүүсийн 9.8 хувийг 1958 онд бүрдүүлж байсан бол 1992 он гэхэд 7.6 хувь болж буурчээ. Өрнийнхний таван том хэл гэж бий. Тэр нь англи, франц, герман, португал, испани хэл. Тэдгээр хэлээр 1958 онд дэлхийн хүн амын 24.1 хувь ярьж байсан бол 1992 онд 20.8 хувь болж буурчээ. 1992 он гэхэд хятадын мандарин хэлээр яригсдын тоо англи хэлтнүүдийн тоотой бараг тэнцэж, дэлхийн хүн амын 15.2 хувьд хүрчээ. Үүнээс гадна дэлхийн хүн амын 3.6 хувийг хятад хэлний бусад аялгаар яригсад эзэлж байв.

Дээрхи махан тоонуудын цаана хүн амын механик өсөлт, Европ дахь төрөлт буурсан, хөгшрөлт явагдсан, одоо өсөөд өсөөд хол ахиагүй гээд олон тайлбар дагалдана. Гэхдээ интернэтийн хэл англи байна, олон улсын бараг бүх хуралд англиар явж байна, Холливуд татан дагуулсаар байна, барууны рок-поп урлаг гандан бууршгүй тархсаар байна гэж үзвэл англи хэл ноёлсоор байгаа.

Дэлхийн хүн амын дийлэнхи нь харийн ганцхан хэлийг (англи) дэлхийнх гэж үзэх нь нэг талаас байж болшгүй мэт. Эх оронч цус нь хөөрсөн монголчуудад энэ хамаатай юу, үгүй юу, бүү мэд?

Янз бүрийн хэлний бүлэг, янз бүрийн соёлд харьяалагдах улс түмний харилцааны гол хэрэгсэл нь англи хэл болчихсон өнөө цагт дэлхийн “lingua franca” буюу хэл шинжлэлийн нэр томъёогоор бол дэлхийн хамгийн “өргөн харилцах хэл” нь англи гэжд таглачихаж болмоор санагдана.

Түүхэн аль ч үед “lingua franca” гэх ойлголт гарч ирж байв. Жишээ нь, сонгодог эртний үе болон дундад зуунд латин хэл, өрнөдөд франц хэл, Африкийн ихэнхи нутагт суахили хэл, харин XX зууны II хагаст англи хэл гэхчлэн. Тэр эрчээрээ явсаар англи хэлээр одоо бараг бүх дэлхийд нэвтрэлцэж байх шиг.

Англи хэл өргөн хэрэглэх болсон нь дэлхийг Англо-Америкийн иргэншилд хэт хамаатуулсных

Их эзэн Чингис хаан маань дэлхийн талыг эзэлж, дэлхийн гүрэн байгуулж явахдаа монгол хэлээ яагаад нэвтрүүлээд үлдээчихээгүй юм бол гэх асуулт аяндаа гарч ирдэг юм. Олон талаас нь тайлбарлаж болно. Монгол гаралтай үгсийн тархалт, гадаад хэлэн дэх монгол үгийн тухайд бол ондоо хэрэг. Тэглээ гээд монгол хэл маань латин, франц, англи хэл шиг тархсангүй. Дэлхийн эзэнт гүрэн байх гэдэг нь цэрэг-зэвсгийн, илд мэсний гэхээсээ илүүтэй, эдийн засгийн, иргэншлийн, түүнийг дагалдаад “lingua francas” бүхий гүрэн байхыг хэлдэг аж. Мэргэдийн онолоос ярьж байна. Тэр шалгуураар бол Чингисийн эзэнт гүрэн нь заримдаг, өв тэгш бус гүрэн байсан болж таарна.

Монгол хэл, монгол ёс заншил, ахуй маань эзэлсэн орнуудынхаа суурь соёл, хэл, шашин, ахуйд уусч тэндээ шингэсэн байдаг. Хэрэв Юань гүрэн дахин 100, 200 жил тогтносонсон бол өнөөгийн манай Монголд юу үлдэх байсныг хэн ч мэдэхгүй.

Үндсэн сэдэвтээ эргэж оръё. Эдүгээ англи хэл бол дэлхийн иргэншлүүдийн хоорондын харилцааны хэрэгсэл болж, христосын он тоолол нь дэлхийн цаг тооллын, араб тоо нь дэлхийн тоолох арга, метрийн систем нь дэлхий даяар хэмжээсийн үүрэг гүйцэтгэж байна. Энэ утгаараа англи хэл маань өрнийнхний геополитикийн нэгэн лут, хүчирхэг зэвсэг ч гэхээс өөр аргагүй.

“Lingua franca” бол хэл, соёлын ялгааг даван туулах арга болохоос бус уг ялгааг арилгах арга хэрэгсэл биш юм. Зөвхөн харилцааг хөнгөвчлөхөөс бус нэгдмэл дүр төрх, хамтын нийгэмлэгийг бий болгож чадахгүй. Монголын бизнесмен, Японы банкир, Индонезийн эрдэмтэн гурав хоорондоо англиар ярьж байгаа нь тэдний аль нэг, эсвэл гурвуулаа англичлагдсан, эсвэл өрнөжсөн гэсэн үг биш юм. Яг үүнтэй нэгэн адил франц, герман хэлээр ярьдаг швейцариуд англи хэлийг үндэсний хэл шигээ өргөн хэрэглэдэг. Энэтхэгт Неругийн саналаас зөрж англи хэлийг албан ёсны хэлээр авч үлдсэн нь хинди хэлээр ярьдаггүй энэтхэгчүүдэд төрөлх хэл, соёлоо хадгалж үлдэх, олон хэлт нийгмийн тогтолцоог хэвээр хадгалах шаардлагаар нөхцөлдсөн зүй ёсны алхам байсан хэрэг.

“Lingua franca” нь ерөнхийдөө нэг угсаатан, шашин, үзэл суртлын бүлэгт хамаарахгүй. Өнгөрсөн хугацаанд дээрхи шинжийг англи хэл харуулж чадлаа. Тэгэх тусмаа орчин үед “угсаа үндсэсээ бүр их холдож” байгаа нөхцөлд англи хэл нь эртний аккад, арамэй, грек, латин хэлний хөгжилтэй төстэй замаар явж байх шиг. Англи хэл ингэж өргөн хэрэглэх болсон нь сүүлийн 30 жилд дэлхийг Англо-Америкийн геополитик ба иргэншилд хэт хамаатуулсных, мөн бусад улс түмэн үндсэрхэг ба үзэл суртлын үүднээс өөрсдийн уугуул хэлээ дэвэргэж чадаагүйтэй холбоотой. Англи хэлийг ийнхүү соёлын харилцааны хэрэгсэл болгосон нь өөр өөр соёл, онцлог төрх бүхий байдлаа улс түмэн хадгалж үлдэхэд тус дөхөм болсон төдийгүй зарим талаар үндэсний ухамсарыг нь сэргээсэн геокультурын хэрэгсэл гэж ч үзэж болно. Гео-шашны нэг үндсэн хэл болох араб хэл мусульман ертөнцийг нягтруулж байвч англи хэлтэй өрсөлдөх хэмжээнд очтолоо өдий байна. Бараг ч үгүй биз.

Англи хэлтэнгүүдийн хувьд англи хэлний олон янзын аялгаар ярих нь улам бүр түгээмэл болжээ. Тухайн ард түмэн англи хэлийг орчиндоо уусган, өвөрмөц онцлогоо тусгаснаар уугуул англи, америкийн аялгаас тэс ондоо хятадын олон хэлнүүд шиг нутгийн олон англи хэл бий болжээ. Нигериа дахь пийжин-англи, энэтхэгийн англи болон бусад хувилбар бол тухайн нутгийн ард түмний соёлд шингэж, ирээдүйд эх англи аялгаасаа тэс өөр болохын цондон юм. Магадгүй латин хэлнээс роман хэл тасран гарсны адил төрөл арилжиж бие даасан хэл буй болж болзошгүй. Гэхдээ итали, франц, испани хэлнээс ялгаатай нь англи хэлнээс салбарлах эдгээр хэл бол тэгтлээ хавтгайрахгүй, эсвэл өөр өөр хэлний аймгуудын хоорондын харилцааны хэрэгслээр үлдэх магадлалтай.

Энэ бүх өөрчлөлтийг Энэтхэгээр жишээлж болно. 1983 онд Энэтхэгийн нийт 733 сая хүн амын 18 сая нь англиар ярьж байсан бол 1991 онд 867 сая хүн амын 20 сая нь, одоо тэрбум гаран хүн амын үсрээд 50 сая нь л ярьж байна. Үүнээс харахад англи хэлээр ярьдаг хүн амын эзлэх хувь харьцангуй тогтвортой буюу ердөө 2-4 хувийг эзэлж байна. Цөөн тооны элит хүрээллээс гадуур англи хэл lingua franca-гийн үүрэг гүйцэтгэж чадахгүй байна. Англи хэлийг эх хэлний онцлогтоо тааруулж хэрэглэн, тэр хэмжээгээр бүс нутгийн, энэтхэгжсэн англи хэл төлөвшиж, эртний санскрит болон перс хэлний нэгэн адил өнөөдөр Энэтхэгийн соёлд шингээжээ. Ингэснээр өрнийнхний геокультурын нөлөөллийг Энэтхэгийн хойгт саармагжуулж, хариуд нь өөрийн геополитикийг сөргүүлж гаргаж ирэх нэг бололцоо бүрдсэн байна.

Түүхэн аль ч үед дэлхийн хэмжээнд хүчний харьцаа хэрхэн тогтож ирсэн нь хэлнүүдийн тархалтад тусгалаа олж ирсэн юм. Энэ бол геополитикийн хууль. Хамгийн өргөн тархсан хэл болох англи, франц, мандарин, испани, араб, орос нь эзэнт гүрний үндсэн хэл байсны үр дүн. Харин бусад улс түмэн ялт ч үгүй тэдгээр хэлээр нэвтрэлцэж, цаадуул нь ч хэлээ түгээхийг идэвхтэй дэмжсээр иржээ. Дэлхийд эрх мэдэл, геополитикийн нөлөө, хүчний харьцаа их гүрнүүдийн дунд харилцан шилжихийн хэрээр хэлнийх нь хэрэглээ аясаар нь шилжиж байв.

Миний энд бичсэнийг эх хэлээ хамгаалъя гэх уриатай, гадаад хэл заалгахгүй гэсэн лоозонтой монгол хэлний эрдэмтэн багш нар маань тогтож, тэвчээр зааж, намайгаа харааж зүхэхгүй шиг уншаарай даа!

(Төгсгөл дараагийн дугаарт)

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИЙН ХИЙ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас. 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас. 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас. 99901532

Гадаад контент, соёл энтертайнментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас. 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Г.Лхагвасүрэн
Утас. 99903581

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас. 70103131,
Факс. 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
Zasag.Co

Дугаарын удирдагч
Б.Даваатогтох

8 658000 029112 00640

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.05.19

Тендер шалгаруулалтын нэр: Ус сувгийн удирдах газарт давснаас хлор гаргах электролизийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.
Тендер шалгаруулалтын дугаар: УСУГ-ХА-2017-03-103

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос давснаас хлор гаргах электролизийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 /тавин мянган/ төгрөгийг Ус сувгийн удирдах газрын Хас банк 5000075928 дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
- Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 1,800,000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 09 дугаар сарын 02-ний өдрийг дуустал.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 30 минутаас 10 цаг 30 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минут-аас нээнэ.
Гадаадын этгээд оролцох эрхгүй.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар
Утас: 70157019-223

ЗГМ: Сэдэв

Хүнсэнд нуугдсан хортой тоглоомууд

Б.Ганбаяр / ЗГМ©

◀1

Энэ нь хүүхдийн нөхөн үржихүй болон мэдрэлийн эдийн хөгжил, бөөр, уушги, гэдэс дотор эрхтэнд сөрөг нөлөө үзүүлэх гол шалтгаан болдог. Тэр дундаа хадгалалтын горим зөрчсөн бүтээгдэхүүн дэх тоглоомоос ялгарах хорт бодис хүүхдийн хүнсэнд илүү ихээр нэвчиж, дотор эрхтнийг гэмтээдэг гэдгийг тус төвийн Эрдэм шинжилгээний ажилтан Г.Уянга хэлсэн юм.

Уг нь хөгжингүй орнуудад тоглоомын импортын асуудалд онцгой анхаарч, лабораторийн шинжилгээнд хамруулан, хүүхдэд хор хөнөөлгүй гэж үзсэний үндсэн дээр өөрийн улсын стандартад нийцвэл импортлох, худалдах зөвшөөрөл олгодог. Гэтэл манай улсад энэ төрлийн хяналт тавих нь битгий хэл анхаарч үзэх улсын байгууллага ч байхгүй байна. Мэргэжлийн хяналтын байгууллага эрсдэлд суурилсан хяналт хийдэг болсноос хойш хүүхдийн тоглоомд тавих хараа хяналт үндсэндээ байхгүй болсон гэхэд хилсдэхгүй. Тэрчлэн бүхэл бүтэн улс байж тоглоомд агуулагдаж буй химийн бодисыг нарийвчлан тогтоодог нэг ч лабораториг үй байгаа нь ирээдүй болсон хүүхдүүдээ хөсөр хаяснаас ялгаа алга.

Эмч, мэргэжилтнүүдийн зөвлөж буйгаар хүүхэд аливаа химийн бодисын нөлөөлөлд өртөмтгий байдаг учир бага хэмжээний хортой зүйл байсан нь ч хүүхдийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, харшилтай болгох, эрүүл мэндээр хохироход хүргэдэг байна. ДЭМБ-ын судалгаагаар жилд 15-аас доош насны 35,000 хүүхэд химийн хорт бодисын нөлөөллөөр амь насаа алддаг төдийгүй түүнээс хэд дахин олон хүүхэд химийн бодисын хурц болон архаг хордлогод өртсөөр байгааг дурдаж ээ.

Уг нь Монгол Улсад хүүхдийн тоглоомын аюулгүй байдлыг хангах стандарт байдаг юм байна. Олон улсын стандартчиллын байгууллагын ISO:8124 "Тоглоомын аюулгүй байдал" дөрвөн багц стандартыг үндэсний стандартаар батал жээ. Энэ стандарт нь хүүхдийн хүнсэн дотор орсон тоглоомд ч хамаатай байдаг гэдгийг мэргэжлийн хүн хэлж буй. Хэдийгээр эдгээр стандарт Монгол улсад мөрдөгдөж байгаа ч хянаж, шалгаж, биелүүлж байгаа нь тун ховор. Бидний хүүхдэдээ худалдан авч өгдөг тоглоомын шошгонд тухайн тоглоомын химийн найрлагыг харуулсан мэдээлэл байдаггүй аж. Тиймээс аюулгүй бүтээгдэхүүн худалдаж авах баталгаа байхгүй гэсэн үг юм. Иймд эцэг, эхчүүд л үр хүүхдийнхээ эрүүл мэндэд эзэн болж, хор худалдан авч балчир үрсийнхээ аманд хийхгүй байх нь энэ аюулаас сэргийлэх ганц гарц болоод байна. [ЗГМ]

» Хүнс, тоглоом аль нь ч бай тухайн бүтээгдэхүүн гарал үүслийн бичигтэй байна.

» Химийн хортой тоглоом хүүхдийн нөхөн үржихүй болон мэдрэлийн эдийн хөгжил, бөөр, уушги, гэдэс дотор зэрэг эрхтэнд сөрөг нөлөө үзүүлдэг.

» Хөгжингүй орнууд хүүхдийн тоглоомын импортын асуудалдаа онцгой анхаардаг.

ЗГМ: ТОДРУУЛГА

Хүүхдийн тоглоомын химийн бодисыг шинжлэх лаборатори байхгүй

Энэ талаар МХЕГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Л.Гэрэлмаагаас тодрууллаа.

-Хүүхдүүдийн иддэг чихэр, жимс зэрэг хүнсний бүтээгдэхүүнд тоглоом дагуулж, савласан байдаг. Тухайн тоглоом нь хүнсний бүтээгдэхүүнд нөлөөлөх, эсэхэд ямар хяналт тавьдаг вэ?

-Хүүхдийн тоглоомд хүнсний бүтээгдэхүүн савласан, эсвэл хүнсний бүтээгдэхүүн дотор хүүхдийн тоглоом хийсэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн байх шаардлага тавьдаг. Тодруулбал, хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, боодол хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ёстой. Түүнчлэн хүнс, тоглоом аль нь ч бай тухайн бүтээгдэхүүн гарал үүслийн бичигтэй, хадгалалтын хугацаатай, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан, шинжилгээний бичигтэй, хүүхдэд гаж нөлөө үзүүлэхгүй л байвал асуудалгүй.

-Хүүхдийн тоглоомонд тавих стандарт гэж байдаг уу. Хүнсний бүтээгдэхүүний хамт савласан тоглоомд ямар стандарт мөрддөг вэ?

-Сургалт хүмүүжлийн байгууллагад эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм гэж байдаг. Хүүхдийн тоглоомд олон улсын ISO стандартыг үндэсний стандарт болгож, дөрвөн цуврал стандартыг мөрдөхөөр зохицуулсан. Хүүхдийн тоглоомын аюулгүй байдалд хяналт тавих стандарт, дүрэм журам, тавих шаардлага маш тодорхой. Харин хяналтыг хэрхэн тавих нь асуудал болдог. Учир нь мэргэжлийн хяналтын байгууллага зөвхөн эрсдэлд суурилсан шалгалт явуулдаг учраас тэр бүр хүүхдийн хүнсэнд орж байгаа тоглоомыг шалгаад байх боломжгүй. Ерөнхийдөө хоёр шатанд хяналт тавина. Хилээр оруулж байгаа тоглоомын гарал үүслийн гэрчилгээ, чанар стандартын шаардлага хангасан, эсэхийг манай хилийн мэргэжлийн хяналтын байцаагчид шалгадаг. Харамсалтай нь, химийн бодисын шилжилт зөвшөөрөх хэмжээнд байгаа, эсэхийг үзэх лабораторийн чадамж төдийлэн сайн биш. Тиймээс бичиг баримтынх нь хувьд шалгаад л оруулчихдаг. Түүнчлэн дийлэнх тоглоомууд хяналт, шалгалтын бичиггүй, хувь хүний гар дээр буюу ганзагын наймаагаар орж ирэх тохиолдол элбэг байна.

-Хүүхдийн тоглоом хүнсний бүтээгдэхүүн хоёрыг хольж болох уу. Ямар нэг хориглосон заалт байдаг уу?

-Хүүхдүүд тоглоомоо гараараа хүрч, амаараа мэдэрдэг. Тиймээс хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөхгүй байх шаардлагыг хамгийн түрүүнд тавина. Харин хамт байж болохгүй гэж хориглосон тодорхой заалт байхгүй. Гэхдээ хүнсний бүтээгдэхүүн дотор тоглоом хийдэг, эсвэл тоглоомон дотор хүнсний бүтээгдэхүүн савлах тохиолдолд хүнсний бүтээгдэхүүнд тавигдах сав, баглаа, боодлын шаардлага тавина. Түүнээс биш хольж болно, болохгүй гэсэн эрх зүйн зохицуулалт байхгүй. Гэхдээ хүнсэнд байгаа тоглоом гадуураа савлагаатай, тухайн хүнсний бүтээгдэхүүнээс тусгаарласан байх ёстой. Задгайгаар нь хийж огт болохгүй.

-Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнд ямар хяналт тавьдаг вэ?

-Хүүхдийн тоглоомын үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд дотоодын хяналтыг тухайн үйлдвэр, импортлогч, худалдаа эрхлэгч, хэрэглэж буй хүүхдийн байгууллага тавьж, ажиллах ёстой. Хөндлөнгийн хяналтыг манай байгууллагаас хилээр оруулж ирэх үед нь тавина. Удахгүй хүнсний бус бүтээгдэхүүний аюулгүй байдлыг зохицуулсан Бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль батлагдана. Ингэснээр хүүхдийн тоглоомд тавих хөндлөнгийн хяналтыг манайхаас хуулиар тавих эрх зүйн орчин бүрдэнэ. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-05-19

Тендер шалгаруулалтын нэр: **Нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ТШ/17/01/ХҮ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 100000 /нэг зуун мянга/ төгрөгөөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн сан банк дахь 100900019002 тоот дансанд тушаан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендер нь дараах 2 багцтай байна:

Багц №1. 120м2 талбай бүхий нийлэг хальсан хүлэмж 520 иж бүрдлийг нийлүүлэх
Багц №2. 32 м2 талбай бүхий нийлэг хальсан хүлэмж 200 иж бүрдлийг нийлүүлэх

Тендерийн хамт өөрийн санал болгож байгаа үнийн дүнгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний тендерийн баталгааг төгрөгөөр ирүүлнэ.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

1. Сүүлийн 2 жилийн борлуултын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 60.0 хувиас багагүй байна.
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээлжих эрх нээлгэсэн зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
3. Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 оны Аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 11 цагаас 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 11 цаг 30 минутад нээнэ.
Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ: Монгол улс, Улаанбаатар хот, Энх тайвны өргөн чөлөө 16А, Засгийн газрын 9 дүгээр байр, ХХААЯ-ны 503 дугаар өрөө
Утас:263408 факс 453121

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.05.19

Тендер шалгаруулалтын нэр: **Ус сувгийн удирдах газарт суудлын автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.**
Тендер шалгаруулалтын дугаар: **УСУГ-ХА-2017-03-133**

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос
Багц: 1 Суудлын автомашин -1
Багц: 2 Суудлын автомашин-2 нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 /тавин мянган/ төгрөгийг Ус сувгийн удирдах газрын Хас банк 5000075928 дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

- **Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.**
- **Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгөөс дээш байх.**
- **Тендерийн баталгаа: Нийт санал болгож буй үнийн дүнгийн 2%-тай тэнцэх төгрөгийн дүнтэй баталгаа ирүүлэх**
- **Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 09 дугаар сарын 01-ний өдрийг дуустал.**

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 09 цаг 30 минутаас 10 цаг 30 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 11 цаг 00 минут-аас нээнэ.
Гадаадын этгээд оролцох эрхгүй.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157019-223

Амьдралын хэв маяг

ЗӨВЛӨГӨӨ

Хор тайлах маскууд

Гэрийн нөхцөлд кофены шааралаар гоо сайхны бүтээгдэхүүн хийх аргуудыг сонирхуулъя.

Нүүрний маск: Хоёр цайны халбага кофены шаарыг хоёр цайны халбага какаоны нунтаг, гурван цайны халбага цэвэр сүү, нэг цайны халбага зөгийн балтай холиод сайтар хутгана. Бэлэн болсон зуурмагаа нүүрэндээ нимгэн түрхээд 15 минутын дараа бүлээн усаар угаагаарай.

Үсний маск: Бүлээн, чихэргүй кофегоор үсээ шавшаад гялгар уутан малгай өмсөж, 20 минутын дараа угаана. Эсвэл кофены шаарыг халуун усаар хандалж, өтгөн болсны дараа үсээ угааж болно. Кофены найрлага дахь кофеин нь үсийг зөөлөн, торгомсог болгохоос гадна хуйханд тэжээл өгч, үс уналтаас сэргийлдэг байна.

Гуужуулагч: Нэг аяга кофены шаар, эсвэл нунтаг кофег тал аяга сахар, нэг аяга оливын тостой хольж, сайтар хутгана. Усанд орсны дараа бэлтгэсэн бүтээгдэхүүнээрээ бүх биеэ үрээрэй. Кофены найрлагатай гуужуулагч нь целлюлитийг арилгахад үр дүнтэй. [ЗГМ]

Органик саван

Нэг халбага хуурай сүү, глицеринтэй саван, бага зэрэг кофены шаар байхад арьсанд тэжээл өгөх саван бэлэн болно. Буцалж буй халуун устай сав дээр дахин нэг шилэн эсвэл төмөр сав давхарлаж тавиарай. Үүндээ сонгосон савангаа хийж, хайлуулна. Дээр нь нэг халбага хуурай сүү, дөрөвний нэг аяга кофены шаар нэмнэ. Сайхан үнэртэй болгоё гэвэл нэг цайны халбага ваниль нэмж болох юм. Эдгээрийг сайтар хутгаад хэлбэр оруулах саванд хийж, сэрүүн газарт хэдэн цаг байлгаарай. Саван биежиж, хатуу болсны дараа савнаас нь гаргахад хэрэглэхэд бэлэн болно. [ЗГМ]

Кофены амттай стейк

АНУ-ын Нью-Йорк хотоос гаралтай кофены үнэр, амттай үхрийн махан стейкийг хийхэд тун амархан. Үхрийн гол махандаа нэг цайны халбага оливын тос түрхээд амтлагчуудыг тус бүр тал халбага хэмжээтэйг цацаж, амтална. Үүнд, кофены үр, элсэн чихэр, давс, хар болон улаан перц, нунтаг сармис орно. Мөн бага зэрэг улаан чинжүү нэмээрэй. Амталсан махаа хоёр цаг байлгасны дараа гриллдэж шарна. Грилл дээр нэг талыг нь хоёр минут байлгаж, ээлжлэн шарна. Кофены үнэр, амт шингэсэн стэйкийг 10 минут хөргөвөл хэрчихэд тохиромжтой болдог юм байна. [ЗГМ]

ТЕХНОЛОГИ

Гар утасны цэнэг "иддэг" үйлдлүүд

Ухаалаг утас олон давуу талтай ч цэнэг нь хурдан дуусдаг. Гар утасны цэнэгээ хэмнэх дараах аргуудыг хэрэгжүүлээрэй.

-Ухаалаг утас хэт хүйтэн, эсвэл хэт халуунд тэсвэргүй. Тодруулбал, нэмэх 30 хэмээс дээш, хасах 20 хэмээс доош байвал утасны зай мууддаг.

-Долоо хоногт хамгийн багадаа нэг удаа утсаа унтрааж байх нь зайны ашиглалтын хугацааг нэмдэг. Утсыг 95-97 хувь хүртэл цэнэглэх нь хамгийн тохиромжтой гэж үздэг тул шөнөжин уяатай хонуулж болохгүй.

-Цэнэглэж л байвал хамаагүй гэвэл хямд цэнэглэгч ашиглах нь буруу. Ялангуяа, богино хугацаанд маш хурдан цэнэглэдэг бол бүр илүү халтай.

-Цэнэгээ хэмнэхийн тулд ашигладаггүй програм, аппликэйшнүүдээ заавал устгаарай. Гэхдээ байнга ашигладаг аппликэйшнээ хаах хэрэггүй. Хэрэв тогтмол ашигладаг бол байн байн ачааллаж, багагүй цэнэг зарцуулна. Мөн андройд утаснуудад цэнэг хэмнэх (batterei saver) програм хэрэглэж болно. [ЗГМ]

Кофены шаар нь органик бүтээгдэхүүний шилдэг орц болдог

Б.Баярмаа
@bayarmaaZGM

С.Батсайхан / ЗГМ©

Хэмнэлтээс "төрсөн" бизнесийн санаа

Сэтгэл сэргэм үнэр, амттай кофе бэлтгэсний дараа шаарыг нь хэрхэх талаар бодож байсан уу. Эрүүл мэндэд олон талын ашигтай кофег нэрсний дараа шим тэжээл нь ямар нэг хэмжээгээр үлдсэн байдаг аж. Хүн төрөлхтөн дэлхий даяар жилд кофены зургаан сая тонн шаар "үйлдвэрлэдэг". Зөвхөн Австралид гэхэд жилд 75 мянган тонныг хаях шаардлагатай болдог бөгөөд энэ хэмжээ жилд 4.3 хувиар өсөж буй. Энэ хэрээр хоол хүнсний хаягдал нэмэгдэж, экологийг бохирдуулж байдаг. Хэрэглэсэн шаараа хэрхдэг талаар Улаанбаатар хотод олон салбартай "Caffe bene" кофе шопоос тодруулахад "Дахин ашигладаггүй, хаядаг" гэлээ. Харин дэлхий нийт энэ хаягдлыг дахин ашиглах хандлагатай болж байна.

Кофены шаарыг хамгийн анх ашигласан нь XIX зуунтай холбоотой. Шаарыг хаяхаас татгалзаж, шинэ үртэй хольж хэрэглэдэг байсан ч энэ нь кофены чанарыг доош татдаг байж. Тиймээс кофены хорхойтнууд, кофе шопууд өөр юунд ашиглаж болох талаар толгойгоо гашилгасны эцэст цөөнгүй санаа олжээ. Шаар нь ургамлын үрний үлдэгдэл учраас органик бүтээгдэхүүний шилдэг орц болдог байна.

УРГАМЛЫН ОРГАНИК БОРДОО

Кофены шаар нь кали, магни, фосфороор баялаг. Азотын хүчлийг хөрсөнд бага багаар шингээдэг учраас сайн бордоо болж чаддаг. Ялангуяа, хүчиллэг орчинд дуртай нэрс жимс, алтан тэрэлж, далий ягаан цэцэг зэргийг ургуулахад тохиромжтой юм байна. Кофены шаарыг бордоотой хольсноор ургамлын өсөлтийг 20 хувиар нэмдэг гэсэн судалгаа гарчээ. Тиймээс сүүлийн үед томоохон сүлжээ кофе шопууд шаарыг хаялгүй гаднах талбай, цэцэрлэгээ тордоход зориулж байна. Тухайлбал, дэлхийн 72 оронд 26 мянган салбартай "Starbucks" сүлжээ 2015 онд төсөл хэрэгжүүлж, кофены шаараа иргэдэд тарааж эхэлжээ. "Starbucks"-ийн нийгмийн хариуцлагын багийн ахлагч Жим Ханна "Энэ бол манай байгууллага, хэрэглэгчид гээд бүгд хожиж буй төсөл. Кофены шаарыг мөнгөөр зараагүй ч байгаль орчноо сайжруулахад зориулж, ургамал тарьдаг иргэдийн хөдөлмөрийг хөнгөвчилж байна" гэжээ.

Кофены шаар хаа сайгүй байдаг учраас түүнийг бордооны зориулалтаар худалдаж авдаг газар тун ховор. Гэхдээ бусад орцтой хольж, органик бордоо болгон зардаг туршлага байдаг аж. Хэрэв ийм бордоог сайн сурталчилж чадвал ирээдүйтэй бизнес гэж энтерпренерүүд үзэж байна.

Бордоотой хольсноор ургамлын өсөлтийг 20 хувиар нэмдэг

АХУЙН ШИЛДЭГ ТУСЛАГЧ

Кофены шааараар биеийн гуужуулагч хийдэг арга дэлгэрээд удаж буй. Түүний араас ийм орцтой саван, үсний маск хүртэл худалдаанд гарсан. Кофены шааараар гоо сайхны бүтээгдэхүүн хийх нь хэмнэлттэй, бас үр дүнтэй. Кофены үр нь арьсны гүн дэх бохирдлыг цэвэрлэж, тэжээл өгдөг учраас органик гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэгчид үүнийг илүү таашаадаг.

Түүнчлэн гэр ахуйн ажилд ч кофены шаарыг ашиглаж болно. Кофены шаар бол модон эдлэлийг хамгийн сайн өнгө оруулдаг эд аж. Хандалж, эсвэл бага зэрэг кофетой холиод модон эдлэлээ зүлгэвэл өнгө ордог. Түүнчлэн аяга таваг, тогоо зэрэг гал тогооны бүхий л сав суулгыг үүгээр үрж, зүлгэж болно. Хөргөгч болон халуун ногоотой хоолны эвгүй үнэрийг үүгээр дардаг. Өрөөний булангаар шавж, хорхой гүйгээд байвал бага зэрэг кофены шаар цацвал хортон шавьж үнэрээс нь дайждаг аж. Мөн нохой, муур зэрэг гэрийн тэжээмэл амьтдын бөөсийг кофены шааараар үрж, арилгаж болно. Энэ мэтээр кофены шаарыг ахуйд хэрэгцээтэй бүтээгдэхүүн болгож, төсөр аргаар мөнгө олох боломж байна. [ЗГМ]

Хөлбөмбөгийн спортыг Монголд хөгжүүлэхэд "МИАТ" хувь нэмэр оруулж байна

Энэ өдрүүдэд Германы алдарт Боруссия Дортмунд багийн багш дасгалжуулагчид Монгол Улсад ажиллаж байна. Тэд "МИАТ" компанитай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Монголын өсвөрийн хөлбөмбөгчдөд хичээл зааж байгаа юм. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн ногоон зүлгэн дээр сургалтын нээлтийн ажиллагаа болж, "МИАТ" компанийн удирдлагууд оролцож, долоон багаас сонгогдсон 50 гаруй хүүхэдтэйгээр сургалтыг эхлүүллээ.

"МИАТ" компанийн тухайд ХБНГУ-ын Бундеслигийн Боруссия Дортмунд багтай хамтран ажиллах гурван жилийн хугацаатай гэрээг 2016 оны долдугаар сард байгуулсан бөгөөд энэ нь Үндэсний Агаарын тээвэрлэгч компани гадаадын нэр хүнд бүхий хөл бөмбөгийн багтай хамтарч ажиллаж байгаа анхны тохиолдол юм. Уг гэрээг байгуулснаар дэлхийн нэр хүндтэй багийн брэндийг ашиглан "МИАТ" компанийг төдийгүй Монгол Улсыг сурталчлах таатай нөхцөл бүрдэх эхлэл тавигдсан гэж үзэж байна. Мөн компанийн зүгээс зөвхөн нислэгийн чиглэлүүдийнхээ ашиг орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр уг хамтын ажиллагааны гэрээг үзэглээгүй, Монголын хөлбөмбөгийн тамирчдын шинэ залуу халааг бэлтгэх, энэ төрлийн спортоор хичээллэж байгаа хүүхдүүдийн авьяасыг хөгжүүлэх, цаашилбал Монголоос дэлхийн хөлбөмбөгчийг төрүүлэх чин зорилго агуулсан гэдгийг "МИАТ" компанийн Гүйцэтгэх захирал Т.Тамир онцолж байлаа.

Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд Боруссия Дортмунд багийн дасгалжуулагч нар жил бүр ирж, хөлбөмбөгийн хичээл заахаар гэрээнд тусгасан нь Монгол Улсад хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэхэд томоохон дэвшил болно гэж МХБХ үзэж байна. Энэ жилийн сургалт тавдугаар сарын 17-22-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд явагдах бөгөөд хүүхдүүдийг МХБХ долоон багаас шалгаруулж авсан байна. Иймхүү Боруссия Дортмунд баг болон МИАТ ТӨХК-ийн хамтын ажиллагаа Монголд хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэхэд өгөөжөө өгч байна.

Авто

ЗӨВЛӨГӨӨ

Гэрлэн бүрхүүл

Хэдийгээр автомашины гэрлийн технологи хөгжиж байгаа ч галоген их гэрэлтэй машинууд байсан хэвээр. Галоген гэрлийн асах хугацаа бусад төрлөө бодвол хамгийн бага байдаг тул шатах нь элбэг. Нэг их гэрэл шатсанаас болж зам муу харагдаад зогсохгүй өөдөөс ирж яваа тээврийн хэрэгсэл баримжаа алдаж, улмаар осол гарч болзошгүй. Иймд, өөрөө гэрлээ солиод сурсан байхад илүүдэхгүй.

ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС

- *Шинэ гэрлийн ламп. Машиндаа таарах их гэрлийн лампыг кодын дагуу худалдаж авна.*
- *Спирт.*
- *Хуурай алчуур.*



Капотоо сөхөөд их гэрлийн ар талыг шалгана. Хэрвээ гар багтахаар зайгүй байвал шил арчигчийн шингэний сав, аккумулятор зэрэг саад болох зүйлсийг авна.



Эхлээд гэрлээ унтрааж, гэрлийн суурийг цахилгаан утаснаас нь салгана. Машинаас хамаараад хуванцар залгуур, металл хавчигч эсвэл эргүүлдэг хийцтэй байж болно. Сүүлийн үеийн машинууд голдуу хуванцар залгууртай байдаг.



- Хуванцар залгуур нь тээглүүртэй байдаг тул залгуурын хэлэн дээр дарж түгжээг мулталж байж татаж сугална.
- Хэрэв эргүүлдэг бол цагийн зүүний эсрэг эргүүлж авна.
- Металл хавчаартай бол шууд эгц хойш сугална.



Эргэдэг хуванцар хүрээ эсвэл ховилтой резин хамгаалалтыг цахилгаан утасны хамт сугалж авсны дараа гэрлийн лампын суурийг салгана.

- Тээглүүртэй хуванцар хүрээг цагийн зүүний эсрэг эргүүлж авна. Хэрэв резин хамгаалалттай бол чихнээс нь татаж мултална.
- Ил харагдах лампын суурийг дарагч нарийн төмрөөр тогтоосон байдаг. Дарагч төмрийн сэртгэрийг цааш дарж аль нэг тийш хөдөлгөн тээглүүрээс мултаслнаар ламп суларна.

Хуучин лампыг сугалж авсны дараа шинэ лампаа спиртээр арчиж байж хийнэ. Спиртээр ариутгалгүй бохир чигээр нь хийвэл ламп түргэн шатах магадлалтай.

- Спирттэй алчууараар арчсаны дараа хуурай салфеткаар тунгалаг болтол нь зүлгэнэ.



- Лампаа үүрэнд нь суулгаад дарагч төмрөөр дарж залгуурыг холбоод асч байгаа эсэхийг шалгана.
- Асч байвал залгуурыг салгаад хамгаалах резин эсвэл эргэдэг хаалтыг хийгээд дахин залгана.



Сэргэн мандалт

Жийп сонирхогч эрэлхэг эрчүүдэд зориулсан хувилбар гарч ирнэ

Өнгөрөгч хавар УАЗ-ын дэргэдэх Шинжлэх ухаан-техникийн төвийн захирал Евгений Галкины ширээн дээр УАЗ-ын логотой жолооны хүрд харагдсан юм. Тэр нь жирийн ч нэг хүрд бус гурван салаа, олон үйлдэлтэй, торгомсог савхин бүрээстэй байв. Намайг ингэтэл сонирхож буйг анзаарсан Галкин тэрхүү рулиэ бушуухан нууж орхилоо. Гэхдээ "бандан тас". Энэ яг шинэ Патриотын руль болж таарсан.

УАЗ МӨН ҮҮ?

Шинэ Патриотыг гаднаас нь сүйдтэй өөрчилсөнгүй. Гагцхүү ондоо хэлбэртэй радиаторын тор, УАЗ-ын томруулсан лого нь Патриотыг илүү сүрлэг харагдуулна.

Хүлээгээрэй, энэ чинь одоо юу вэ? Нүдэндээ ч итгэхгүй нь! Зүүн талд байсан бензин бакны люк алга болчихож! Ашгүй дээ, УАЗ нэг бактай болсноор бензин насосны хэрэгцээгүй боллоо. Тэр ч бүү хэл цагийн аясаар зэвэрч, шатахууны шүүр бохирдуулж байсан төмөр бакыг хуванцар болгосон гэхэд бод доо. Шүүр бохирдох асуудлыг энэ маягаар үндсээр нь үгүй хийсэнд талархаад ханашгүй.

» Дуу чимээ намсгаж, доргилт багасгах тал дээр шинэ Патриот өмнөх үеэ хол хаяжээ.

» Ойрын ирээдүйд Патриотыг турбо хөдөлгүүртэй болгоно гэсэн.

» Говь, хангай хосолсон газар зорчих үеэр хөдөлгөөн хөнгөвчлөх олон янзын шинэлэг зүйлсээрээ бусдаас онцгойрох аж.

Ингээд жолоочийн суудалд тухлаад авлаа… Патриот минь ээ, би чамайг үнэндээ тань-сангүй! Загварлаг, ухаалаг, орчин үеийн машин болсон байна шүү дээ, чи минь! Урд самбар дээрх никель оруулгыг харангуутаа л уг машин илүү дээд зэрэглэлийнх болсныг шууд ойлголоо.

Нөгөөх гурван салаа рулийг өмнөх шигээ нууцаар бус өөдөөс нь харж сууна. Air Bag гэсэн бичиг шууд л нүдэнд туслаа. Хамгийн гоё нь өнөөх руль чинь нааш цааш, дээш доош тохируулгатай.

Өдгөө жолоочийн суудал дээр тарган туранхай, өндөр нам гэлтгүй ямар ч хүн тухалж явна. Энэ бүхэн дээр нэмээд халдаг рулийн ачаар хахир өвлийн хүйтэнд хамгийн хэрэгцээтэй үйлдэлтэй болсон анхны орос автомашин боллоо. Чи үнэхээр УАЗ мөн үү?

Хуучны бүдүүлэг бөгөөд хүч шаарддаг, дуу шуу ихтэй жолооны хүрдэн дээрх янз бүрийн шилжүүлэгчийг орчин үеийн, олон үйлдэл бүхий эвтэйхэн хийцээр сольжээ.

Хуучин агааржуулагчийн оронд хүчин чадал ихтэй агааржуулалтын нэг бүст иж бүрэн систем суурилуулжээ. Хуучны агааржуулагч нь агаарын дулааныг ердөө 9 градусаар бууруулж чаддаг байсан бол өнөөгийнх нь гадаа +35 байхад салоныг 12 градусаар сэрүүн болгоно. Өвөл ч тэр нэмэлт халаагч ашиглах шаардлагагүй.

АЯНЫ ХЭРЭГСЛЭЭ БЭЛДЭЦГЭЭЕ

Дуу чимээ намсгаж, доргилт багасгах тал дээр шинэ Патриот өмнөх үеэ хол хаяжээ. Урьд нь жолоочид арын зорчигчдын, харин тэдэнд жолоочийн яриа сонсогддоггүй байсан бол өдгөө энэ дутагдлыг бүрмөсөн шийдэж, хойно сууж явсан Галкины сонирхолтой яриа ч сайн сонсогдож байлаа. Тэрбээр "Патриотод хийсэн жинтэй шинэчлэлийн нэгд тогтворжуулах систем зүй ёсоор тооцогдоно. ESP тохируулах ажлыг Германд зун, өвлийн замаар бүтэн жил туршсаны эцэст дуусгасан. Үр дүнд нь үнэхээр дажгүй системтэй болсон юм даа" хэмээв.

Ер нь Патриотын хувьд ESP нэг төрлийн гоёо биш гэж үү? Худалдан авагчдыг татах гэсэн маркетингийн нэг санаа... Төмөр сайтай энэхүү машинд орчин үеийн цахим системийн хэрэг юун? Гэтэл би буруу бодож байж. Үнэн хэрэгтээ энэхүү системийн давуу тал үй олон ажээ. ESP халтиргаа ихтэй зам дээр хөдөлгөөний тогтвортой байдлыг хангаад зогсохгүй өөд өгсөх үед Hill Hold Control үйлдлийнхээ тусламжтайгаар машиныг тогтоон барьдаг байна.

Хөдөлгүүрийн тухайд өөрчилсөн зүйл алга. Гэхдээ хүч нь хэзээд хангалттай байсныг бид сайн мэднэ. Сонирхуулахад, тун ойрын ирээдүйд Патриотыг турбо хөдөлгүүртэй болгоно гэсэн шүү.

Цаашид шинэчлэлт үүгээр зогсохгүй аж. 2017 онд гэхэд л жийп сонирхогч эрэлхэг эрчүүдэд зориулсан хувилбар гарч ирнэ. Уг машинд хуваарилах хайрцаг удирдах хөшүүрэг, арзгар хээтэй дугуй, урд гуперт суурилуулсан лебёдк, илүү бат бөх шал гээд говь, хангай хосолсон газар зорчих үеэр хөдөлгөөн хөнгөвчлөх олон янзын шинэлэг зүйлсээрээ бусдаас онцгойрох аж.

Үүгээр гэнэтийн бэлэг дуусахгүй гэдэг нь Галкины зальжин харцнаас шууд ойлгогдож байв. Тиймээс аяны хэрэгслээ бэлдээд хүлээх л үлдлээ дээ!

За рулем

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.05.19

Тендер шалгаруулалтын нэр: Ус сувгийн удирдах газарт нефтийн бүтээгдэхүүн болон нийт өөх, тос тодорхойлогч нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: УСУГ-ХА-2017-03-102

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос нефтийн бүтээгдэхүүн болон нийт өөх, тос тодорхойлогч нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 /тавин мянган/ төгрөгийг Ус сувгийн удирдах газрын Хас банк 5000075928 дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 1,400,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 09 дугаар сарын 03-ний өдрийг дуустал.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 09 цаг 30 минутаас 10 цаг 30 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 11 цаг 00 минут-аас нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар

Утас: 70157019-223

Лавлах

УЛААНБААТАР

Залуучуудын хөдөлмөрийг дэмжих төвтэй боллоо

Г.Төгс
ЗГМ

Залуучуудын хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагаа явуулах "Нийслэлийн залуучуудын хөгжлийг дэмжих төв" өнөөдөр нээлтээ хийнэ. Тус төвийн үйл ажиллагаа эхэлснээр мэдээллийн технологийн чиглэлээр залуусыг үнэ төлбөргүй сургалтад хамруулах болон ажлын байртай болгох боломцоо бүрдэх юм. Уг үйл ажиллагааны нээлтийн үеэр Солонгосын мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 аж ахуйн нэгж оролцоно. Цаашид Япон, Энэтхэг, Солонгос, Тайвань зэрэг орнуудад хөдөлмөр эрхлэх ч боломж бүрдэнэ. "Залуучуудын хөгжлийг дэмжих төв"-ийн дэргэд залуучуудыг бизнесээ эхлүүлэх бүхий л боломжоор дэмжих зорилготой "Бизнес инкубатор төв"-ийг ажиллуулах юм байна. Тус төвөөс нийгмийн сайн сайхны төлөө ажилласан залуучуудыг нэгдсэн бүртгэлд хамруулж, ажилласан цагийг баталгаажуулсан албан ёсны тодорхойлолтыг НЗХГ-ын нэрийн өмнөөс монгол, англи хэл дээр олгох юм. Ингэснээр залуучууд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, гадаад дотоодын их, дээд сургуульд суралцах, төрийн байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд ажилд ороход ажлын туршлага, давуу тал болно. [ЗГМ]

ХӨТӨЧ

Жуулчид Гэрлэх ёслолын ордонд саатна

Аялал жуулчлалын оргил үе буюу зуны урин дулаан цаг ирж буйтай холбогдуулан аяллын маршрутад Гэрлэх ёслолын ордныг нэмж, баяжууллаа. Энэхүү үйл ажиллагаанд нийслэлийн Аялал жуулчлалын газар, "Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ-ын удирдлагууд хамтран ажиллахар болсон байна.

Энэхүү шинэ үйлчилгээг нэвтрүүлснээр жуулчдын аюулгүй байдлыг хангаж, тав тухтай орчинд үйлчлүүлэх, аялал жуулчлалын тур компаниудын хүрээнд шинээр аяллын бүтээгдэхүүн бий болгох аж. Ингэснээр жуулчид үндэсний хурим ёслолын үйл ажиллагаа, ёс заншилтай танилцах боломжтой. [ЗГМ]

ӨДӨРЛӨГ

Мэдээлэл, үйлчилгээг нэг дороос аваарай

Өнөөдөр Сүхбаатарын талбайд Стандарт, хэмжил зүйн газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг 10-16 цагийн хооронд болно. Харин өчигдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын өдөрлөг болов. Тус арга хэмжээнд эрхээ хасуулсан тохиолдолд дахин жолооны эрх олгох шалгалт өгөх, хуучин үнэмлэхийг сэргээх, лавлагаа, тодорхойлолт болон ял шийтгэлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Энэ үеэр Лицензийн иргэдэд үйлчлэх төвийн мэргэжилтнээс жолооны үнэмлэхний хэвлэлт болон түр үнэмлэхийг хэзээ баталгаажуулах эсэх талаар тодруулахад "Одоогоор үнэмлэхний энэ асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа тул хэзээ хэвлэгдэх нь тодорхойгүй байна" гэв. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	**09.45** "Эрдмийн хэт" нэвтрүүлэг	**08.00** "Bloomberg Daybreak Asia"	**09.45** "Би Монгол хүн" нэвтрүүлэг	**10.30** "Цэнхэр тэнгисийн домог" СОАК
12.00	**11.00** "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр	**11.30** "Шилдэг санаа" нэвтрүүлэг	**13.15** "Кино миний амьдрал" нэвтрүүлэг	**12.30** "Сонсъё, Суръя, Дагая" хүүхдийн нэвтрүүлэг
14.00	**14.00** "Цэлмэг" өдрийн хөтөлбөр	**14.10** "Ногоон хот" нэвтрүүлэг	**14.10** "Ялалт" ток шоу нэвтрүүлэг	**14.00** "Египетийн түүх" баримтат кино
18.00	**16.00** "Өвлөхүйн эрдэм" хөрөг нэвтрүүлэг	**17.00** "Bloomberg Surveillance"	**17.30** "Cinema Awards" шууд	**18.30** "Тог тог тог" нэвтрүүлэг
20.00	**19.10** "Би би" бага насныханд зориулав	**20.00** "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг	**20.30** "Сэвэлзүүр салхи" ОАК	**19.30** "Ороод гараач" нэвтрүүлэг
22.00	**21.05** "Баасан гараг" цэнгээнт нэвтрүүлэг	**22.00** "Америк хэрхэн ажилладаг вэ" нэвтрүүлэг	**23.10** "Мердокийн тайлагдашгүй нууцууд" ОАК	**22.30** "Чадвал намайг хуур" ОАК

ОНЦЛОХ ҮЗВЭР

Өнгөрсөн зууны дурлалын түүх өнөө цагт

Францын хөгжмийн зохиолч Л.Герольдын хөгжим "Дэггүй Лиз" хайр дурлалын түүхийг өгүүлэх бүжгэн жүжгийг энэ сарын 27, 28-нд Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа толилуулахаар болжээ. Сонгодог урлагийн тайзнаа өнөөдрийг хүртэл үзэгч олны талархлыг хүлээсэн тус жүжгийг анх 1789 онд нэрт балетмейстер Жан Доберваль Франц ардын аялгуун дээр зохиомжлон туурвиж байсан юм. Хатагтай Марцелина Лиз гэх ганц охинтойгоо нэгэн жижигхэн тосгонд тариалан эрхлэн амьдардаг. Хатагтай өөрийн охиныг чинээлэг айлын хүү Никез гэх залуутай гэр болгохыг хүснэ. Гэвч түүний охин Колен гэх залуутай хайр сэтгэлтэй болсноор ээдрээт хайрын түүх эхэлснээр үзэгдэл өрнөнө. [ЗГМ]

ҮЗВЭР

УЛСЫН ФИЛАРМОНИ
Герман улсын "Minguet quartett" хамтлагийн сонгодог хөгжмийн концерт өнөөдөр 19.00 цагт болно.

АСА ЦИРК
Дуучин Б.Аззаяагийн "Сүүн далай ээж" анхны бие даасан тоглолт энэ сарын 27-нд болно. Тоглолтод бүжгийн "Угсаатан" хамтлаг, амьд хөгжмийн "Logos" хамтлаг болон циркийн уран бүтээлчид оролцох аж.

УЛААНБААТАР ЧУУЛГА
Хөгжмийн зохиолч И.Ф.Стравинскийн бүтээл "Ариун хаврын тахилга" этно балетыг энэ сарын 29-нд тайзнаа дахин амилуулахаар болжээ.

УДБЭТ
Их зохиолч Д.Нацагдоржийн "Ламбугайн нулимс" зохиолоос сэдэвлэсэн дуурийг маргааш 17.00 цагт толилуулна.

THE CORPORATE HOTEL AND CONVENTION CENTRE
Монголын кино урлагийг дэлхийн тавцанд гаргах зорилготой, кино урлагийн дээд шагнал гардуулах "Cinema Awards" ёслолын үйл ажиллагаа өнөөдөр болно. Ёслолын үйл ажиллагаа 16.30 цагт эхэлж, 18:00 цагт шагнал гардуулах аж.

ТУСГААР ТОГТНОЛЫН ОРДОН
"Андууд" хамтлагийн "Андууд" цомгийн баяр маргааш 19.00 цагт болно. Тоглолтод "Гурван охин" хамтлаг, дуучин Б.Маралжингоо, "Камертон" хамтлагийн дуучин Л.Ган-Эрдэнэ болон дуучин П.Баярцэнгэл нар оролцоно.

ZIFERBLAT
Амьд хөгжмийн "Cold play" хамтлагийн ковер тоглолт энэ сарын 27-нд болно. Тоглолтод "Andromeda", "Caffeine" хамтлагууд оролцох юм. Тасалбарын үнэ 8000 төгрөг.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

1. Хөгжмийн зэмсэг
2. Монголын хамтлаг
3. Ухамсар анхдагч уу, ...?
4. Шинжилгээ лабораторийн төв
6. Захидал
7. Эртний хүчирхэг гүрэн
8. Гарц
11. Манай дэлхийд хамгийн ойр орших од
12. Ховдын Цэцэг нуурын дугуйлан, тэмцэгчдийн ахлагч Аюушийн хоч

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Волга (Ижил) мөрний эрэгт орших Торгууд
яастан
5. NBA-ийн алдарт баг
6. Монголын ардчилсан хувьсгалын удирдагч агсан
9. Эрхтэн
10. Хангалт

Өмнөх дугаарын хариу / 05.18

Б	О	О	М	■	■	Т	■	■	Т	А	Я	Н
А	■	■	Ө	Д	■	А	■	Х	У	■	■	А
Н	■	■	Н	■	У	Л	З	■	Н	■	■	Й
Ш	А	Н	Х	■	■	И	■	■	Б	А	Н	З
■	Р	■	Г	■	О	Б	Ь	■	А	■	О	■
■	А	■	А	■	■	А	■	■	А	■	М	■
Г	А	Л	Д	А	Н	Б	О	Ш	И	Г	Т	■
■	Б	■	■	Р	■	■	Р	■	■	О	■	■
■	Э	■	■	Ц	Ү	Ү	Ц	■	■	Н	■	■

ЗГМ: СУДОКУ

				9		8		4
				6				
	8	1		3				
6		4	3					
		3			2	7		6
		8						
3	9					6	4	7
7		6						5
					5			

6	3	7	5	1	9	2	4	8
8	2	4	7	6	3	9	1	5
9	1	5	2	8	4	7	3	6
2	4	8	6	5	1	3	7	9
7	6	9	3	2	8	1	5	4
1	5	3	9	4	7	8	6	2
5	7	2	1	9	6	4	8	3
3	8	6	4	7	2	5	9	1
4	9	1	8	3	5	6	2	7

(Өмнөх дугаарын хариу)

ЗУРХАЙ

Билгийн тооллын 23
Хаврын адаг хөх луу сарын долоон улаан мэнгэтэй улаан морь өдөр.
Үс засуулбал: Эд эдлэл идээ ундаа олдоно.
Наран ургах, шингэх: 05.16-20.29
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Хурьцахуй

Аргын тооллын тавдугаар сарын 19, Сугар гараг. Билгийн тооллын 23, чөдөр одтой, улаан морь өдөр.

Өдрийн наран 05.16 цагт мандан, 20.29 цагт жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, зэрэг дэвших, гарагийг тахих, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

V.19	V.20	V.21	V.22	V.23
17° / 12°	15° / 1°	14° / 1°	18° / 2°	20° / 2°
14м/с / 12м/с	12 м/с / 9 м/с	8 м/с / 7 м/с	8 м/с / 7 м/с	8 м/с / 7 м/с
Үүлшинэ	Ялимгүй хур тунадастай	Үүл багасна	Үүлшинэ	Үүлшинэ



APARTMENTS FOR RENT

The best structured and modern space utilization solutions are maintained and located at the center of the city 27m2 to 50m2 1 to 2 room apartments are offered to you live alone or with your family. The advantages are you can feel comfortable as your own home and easily reach variety of services.

* Staffs are on call 24 hours a day to handle emergencies / English and Japanese-speaking available /
* Laundry
* Taxi service
* Housekeeping
* Translation and guiding services
* Mail delivery
* Press ordering and delivery /Personal press subscriptions/

Хамгийн оновчтой зохион байгуулалттай, орчин үеийн зай талбай ашиглалтын шийдлээр засаж тохижуулсан, хотын төв цэгт байрлалтай 27м2-50м2 1-2 өрөө орон сууцнуудаа ганцаараа болон гэр бүлээрээ амьдрах та бүхэнд санал болгож байна. Та өөрийн гэртээ байгаа мэт тав тухтай байдлыг мэдрэхийн зэрэгцээ төрөл бүрийн үйлчилгээг авах боломжтойгоороо давуу юм.

* 24 цагийн дуудлага хүлээн авах /англи, япон хэлтэй ажилтан/
* Хими цэвэрлэгээ
* Такси дуудлага
* Гэр цэвэрлэгээ
* Гадаад хэлний орчуулга, хөтөчийн үйлчилгээ
* Шуудан хүргэлт
* Хэвлэл захиалга, хүргэлт




Холбоо барих утас: 99092533, Хаяг: 1.Их дэлгүүрийн зүүн талд 1-р байр, 2.Туул рестораны баруун тал 35-р байр, 3. Хүүхдийн 100-гийн Наран моллын урд 8-р байр

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Москва	13.50	14.28
Эрээн-УБ	18.00	11.15
УБ-Эрхүү	21:10	02:40
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Хөх хот	20:00	20.49
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Эрдэнэт	20:30	07:45
Эрдэнэт-УБ	19:10	05:48
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03
Сайншанд-УБ	20:25	07:01
УБ-Сайншанд	09:15	19:15
Зүүнхараа-УБ	04:25	08:40

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	18.55	20.10
Бээжин-УБ	21.10	00.40
Сөүл-УБ	14.20	17.50
УБ-Сөүл	09.45	12.50
Токио-УБ	14.40	20.10
УБ-Токио	08.55	13.40
Хонконг-УБ	12.00	17.40
УБ-Хонконг	07.20	10.50

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Гурван тэрбумын үнэтэй Хонконгийн газар

Henderson-ий өгсөн нийт үнэ Хонконгийн хувьд хамгийн өндөр үнэ болсны зэрэгцээ нэгж үнэ ч дээд хэмжээг тогтоолоо. > 10

Tencent-ийн мобайл тоглоомын ашиг тэнгэрт хадав

Tencent-ийн мобайл тоглоом, цэнгээнт болон нийгмийн сүлжээний аппууд Хятадын зах зээлд тэргүүлэв. > 10

Ногоон хувьсгал Африкийн боломжийг нээнэ

Тус тив жилдээ 40 тэрбум ам.долларын хүнс импортолдог авч хөдөө аж ахуйн том үйлдвэрлэгч болох боломж бий. > 10

Бээжингээс Пакистанд хэрэгжүүлж буй "Зууны төслүүд"

◀1

Өрсөлдөж дийлэхээргүй хямд бүтээгдэхүүнийг хятадууд манайд шахна гэсэн айдас бий. Гэхдээ бидэнд Хятадаас өөр сонголт байхгүй" хэмээн тус улсын худалдааны сайд Куррам Дастгир Хан тайлбарлав. Пакистаныг хөрш Энэтхэг төдийгүй, үйлдвэрлэлийн томоохон бааз байгуулж амжсан Бангладештай харьцуулахад эдийн засгийн хүндрэлтэй байгааг сайдын үг нотлов.

Улс төрийн тогтворгүй байдлаас мултарч, дэд бүтцээ хөгжүүлэхээр чармайж буй хөршдөө Бээжин 55 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй. Үүнд цахилгаан станц, авто болон төмөр зам байгуулах дэд бүтцийн төсөл багтаж байна. Хятадын төслүүд ирэх таван жилд дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувийг эзэлж, эдийн засгийг дахиад гурван хувиар өсгөж өгнө хэмээн Пакистаны бизнесийн зөвлөл тооцоолжээ.

Валютын хямралаа шийдвэрлэхэд нь туслах үүднээс Бээжин өнгөрсөн сард нэг тэрбум ам.долларын зээлийг Исламабадад олгосон. Хятадууд хөрөнгө оруулалтаа ашиглан, харьцангуй ядуу хөршийнхөө нөөц баялгийг өөрийн болгож, улс төрийн эрх мэдлээ тогтооно гэсэн иргэдийн айдсыг ийм зээл багасгаж өгнө хэмээн Пакистаны бодлого тодорхойлогчид найдаж байна.

"Нэг бүс-нэг зам" төслийн хүрээнд, хэнд нь ашигтайд эргэлзэн байж Бээжин хөрш улсдаа 55 тэрбум ам.долларын хөрөнгө цутгаж байна.

BBM©

СРЕС тоон үзүүлэл

- **55 тэрбум ам.доллар- Бээжингээс Пакистанд хэрэглэх төслүүд**
- **35 тэрбум ам.доллар- Пакистаны эрчим хүчний дутагдлыг арилгах 21 цахилгаан станцад зарцуулах зардал**

Пакистаны 20 тэрбум ам.долларын хэмжээтэй худалдааны алдагдлын гуравны хоёр нь БНХАУ-д ноогддог. Хятадаас хөршдөө экспортлох бараа бүтээгдэхүүний хэмжээ 2012 онд 9.3 тэрбум ам.доллар байснаа 2012-2015 оны хоорондох гуравхан жилд даруй 77 хувиар өсөж, 16.5 тэрбум ам.долларт хүрчээ. Энэхүү жолоогүй өсөлттэй уялдан Бээжингийн төслүүдэд сэжиглэнгүй ханддаг хүмүүс цөөнгүй. "Энэ олон төслийн айдам хүрэм сөрөг тал нь" хэмээн Пакистаны хамгийн том хот, бизнесийн гол төв Карачи дахь ажил хэрэгч нэгэн өгүүлсэн юм.

Хил залгаа хөрш хоёр орны Засгийн газрыг хөндийрүүлэхгүй гэсэн бодлын үүднээс СРЕС-ийг ил тод шүүмжлэх зоригтон гардаггүй. "Хажууд маань аварга хөрш оршиж байгаа. Энэ хөршийн хувьд бид мужаас нь ялгаагүй" хэмээн тэрбээр тайлбарлаж байна.

Хятадын талаас дэвшүүлсэн, СРЕС-ийн хэлэлцээрийн анхны эх хувилбар энэ долоо хоногт Пакистаны Dawn сонинд нийтлэгдсэн нь хүмүүсийн түгшүүрийг ихэсгэлээ. Уг хувилбарт Бээжингийн газрын тос, аюулгүй байдлын бодлогод төдийгүй Шиньжяны өөртөө засах орны хөдөө аж ахуйд амин чухал үүрэг гүйцэтгэдэг, хагас цэргийн байгууллага болох Шиньжяны үйлдвэрлэл, барилгын корпорацид давуу эрх олгох заалт байгаа.

Пакистаны хөрөнгө оруулалтын томоохон компанийн захирал уг заалтыг Энэтхэгт Британийн засаглал тогтох замыг зассан худалдааны байгууллагын түүхтэй харьцуулж байв. "Бид маш хянуур хандахгүй бол Британийн Ост-Индийн компанийн түүх давтагдаж болзошгүй. Алдаа гаргах л юм бол түүх давтагдаж л таарна" хэмээн тэрбээр анхааруулаа.

БНХАУ нь СРЕС-ийн хүрээнд дөрвөн үндсэн зорилт тавиад байгаа. Үүнд, Пакистаны өмнөд эргийн Гвадар боомт хүртэл коридор үүсгэх. Уг боомтыг хятадууд санхүүжүүлж, босгон, эзэмших юм. Хоёрдугаарт, цахилгаан эрчим хүчний хүчирхэг сүлжээ байгуулах. Гуравдугаарт, авто болон төмөр замын шугам татах. Дөрөвдүгээрт, үүсгэсэн шугамын дагуу эдийн засгийн тусгай бүс бий болгох. Уг тусгай бүсэд ажиллах Хятадын компаниуд татвараас чөлөөтэй ажиллана.

Дэд бүтцийн салбарт Исламабадын хүч хүрэхгүй байгаа ажлыг Бээжин хийж өгнө. Пакистаны цахилгааны хэрэглээний оргил ачаалал зургаан гигаватт байгаа нь тус улсын цахилгаан станцуудын хүчин чадлаас хэтэрчээ. Энэ нь дунд зэргийн нүүрсний 12 цахилгаан станцын гаргадаг эрчим хүчтэй тэнцэнэ. Одоогоор Пакистаны олон газарт өдөрт хэдэн цагаар тог таслах нь нийтлэг үзэгдэл.

Энэхүү бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд Хятадын тал 35 тэрбум гаруй ам.долларын зардал гаргах гэж байгаа нь СРЕС-ийн нийт төсвийн гуравны хоёрыг эзэлж байна. Бээжин Пакистанд дулааны нийт 21 цахилгаан станц шинээр байгуулж өгөх, эсвэл байгуулахад нь туслах юм. Эдгээрийн ихэнх нь нүүрсэн галлагаат дулааны цахилгаан станц. Үүний дүнд Пакистаны цахилгааны хомсдлыг хоёр дахин нөхөхүйц эрчим хүч үйлдвэрлэдэг болох юм.

СРЕС-тэй холбоотой бүтээн байгуулалтын ажил Пакистаны хүнд үйлдвэрлэлд хэдийнэ түлхэц өгч эхэлсэн. БНХАУ-аас хэрэгжүүлж буй төслүүдийн ачаар цементийн үйлдвэрлэл гурав дахин нэмэгдсэнийг Пакистаны гол конгломератын нэг Arif Habib компани тайлбарлав.

FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Тус компани түрээсийн нэгж фут талбайн үнийг жилд 419 ам.долларт хүргэх шаардлагатай болж байгаа нь арлын төв дэх хамгийн эрэлт-тэй барилгууд болох Олон улсын санхүүгийн төвийн хоёр цамхгийн талбайн түрээсээс 50 хувь дээш гарахыг Nomura фирмийн шинжээчид тооцоолжээ.

Гурван тэрбумын үнэтэй Хонконгийн газар

Женнифер Хьюз

Хонконгийн үл хөдлөхийн компани таван давхар машины зогсоолд гурван тэрбум ам.долларын үнэ өгсөн нь тус арлын зах зээл ямархуу өрсөлдөөнтэйг харууллаа. Тус арлыг 1997 онд Британийн захиргаанаас Хятадад шилжүүлснээс хойш анх удаа хотын төвд газар худалдаж байгаа нь энэ юм. Энэхүү наймаа дэлхийн хамгийн үнэтэй хотыг бусдаас бүр ч дээш ахиулсан явдал болов. Орон нутгийн барилгын Henderson компани 31000 шоо фут талбайн нэг шоо фут тутмыг нь 6400 ам.доллараар худалдан авсан бөгөөд цааш нь хөгжүүлбэл илүү ашиг олох боломжтой.

Henderson-ий өгсөн нийт үнэ Хонконгийн хувьд хамгийн өндөр үнэ болсны зэрэгцээ нэгж үнэ ч дээд хэмжээг тогтоолоо. Ингэснээр тус компани түрээсийн нэгж фут талбайн үнийг жилд 419 ам.долларт хүргэх шаардлагатай болж байгаа нь арлын төв дэх хамгийн эрэлт-тэй барилгууд болох Олон улсын санхүүгийн төвийн хоёр цамхгийн талбайн түрээсээс 50 хувь дээш гарахыг Nomura фирмийн шинжээчид тооцоолжээ. Хонконгод оф-фисын түрээсийн үнэ тэнгэрт хадсаны дээр хоосон байрны олдоц муу тул Хятадын баян түрээслэгчид хоёр цамхгийн түрээсийг нэгж нь 279 ам.доллар болтол өсгөсөн аж.

Ийм үнэ дэлхийд өртөгөөрөө хоёрт бичигддэг Нью-Иоркийн жишихүйц барилгын түрээсээс 75 хувь дээгүүр юм. Гэхдээ үл хөдлөхийн шинжээчид Henderson ийм үнэ төлсөн нь харамсалтай гэхээс илүү газар нэн ховор байгааг бодолцож үзвэл алсын хараатай худалдан авалт болохыг онцолсон байна. Хонконгод байрладаг үл хөдлөхийн шинжээч Питер Чарчхаус "Хэтэрхий мэт санагдаж магадгүй ч тэнэглэл лав биш. Хүүгийн түвшин нэмэгдэж байгаа үед өндөр үнэтэй мэт боловч ерөнхийдөө үндэслэлгүй үнэ биш" хэмээн дүгнэв.

Хонконг, Сингапур, Токио зэрэг Азийн томоохон хотуудад арилжааны үндсэн хөрөнгүүд газраа худалдах нь маш ховор. Жишээ нь, Jardine Matheson компани анх 1901 онд хотын төвд худалдан авсан газраа одоог хүртэл хадгалж байна. Ойрын хэдэн жилдээ энд газар худалдах төлөв харагдахгүй байгаа. Чарчхаус хэлэхдээ тус компани 1980-аад онд Exchange Square гэдэг талбайг худалдан авсан боловч үнэ нь 70 хувь унасныг тэмдэглэв. Үүний улмаас эднийх бараг дампуурахад хүрсэн бөгөөд гашуун сургамжаа санан яаран худалдан авалт хийхээс болгоомжилдог болжээ.

Энэ нь бас Henderson-ий худалдан авалтад дэмжлэг болсон байна. Хендерсон Ланд компанийг 21 тэрбумын хөрөнгөтэй Хонконгийн хоёр дахь баян Ли Шау Ки эзэмшдэг гэж Bloomberg мэдээлсэн. 89 настай ноён Ли хотын хамгийн баян эзэн Ли Ка Шингээс зургаан сараар ах гэнэ. Тэргүүн баяны Cheung Kong групп мөн дээрх газарт худалдаанд үнэ өгчээ. Энэ газар нь Goldman Sachs, Bloomberg, Barclays зэрэг компаниудын байрладаг Cheung Kong цамхаг болон түүний эзэмшлийн жижиг газрын дунд оршдог. Ли Ка Шин томоохон барилгын төсөлд оролцож байсан бол Henderson компанид өөрийн нэрийн цамхаг байхгүй аж.

FT

Tencent-ийн мобайл тоглоомын ашиг тэнгэрт хадав

Юан Ян

Хятадад тэргүүлэгч технологийн компани зар сурталчилгааны орлого болон мобайл тоглоомын зах зээлд зонхилох байр суурьтаа тулгуурлан оны эхний улиралд өнгөрсөн оны мөн үеэс ашгаа 58 хувь өсгөж чадсан байна. Жилийн орлого нь 7.2 тэрбум ам.долларт хүрч, Thomson Reuters-ийн гаргасан шинжээчдийн таамгаас давсан бөгөөд ашиг нь 14.48 тэрбум юань болжээ. Tencent-ийн мобайл тоглоом, цэнгээнт болон нийгмийн сүлжээний аппууд Хятадын зах зээлд тэргүүлэв. Эдний хамгийн түгээмэл апп WeChat-ийг Хятадын мобайл интернэт хэрэглэгчдийн олонх ашигладаг ба тэдний тал нь өдөртөө энэ аппликейшнд цаг хагасыг зарцуулдаг байна.

WeChat нь мессеж, нийгмийн сүлжээ, мобайл төлбөр болон аяллын захиалгыг хүртэл багтаадаг бөгөөд заримдаа түүнийг нийтийн үйлчилгээ хэмээн нэрлэдэг. Tencent-ийн орлогын түргэн нэмэгдэж байгаа хэсэг нь нийгмийн сүлжээ болон бусад зар сурталчилгааны орлого юм. Түүний хэмжээ өмнөх оноос 67 хувь өсөж, 4.38 тэрбум юаньд хүрсэн байна. Тус компани WeChat-ийн найз нөхдийн бүлэгт өдөрт хоёроос илүүгүй зар тавих хязгаарлалтаа хадгалахаар шийдсэн нь хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлсэн шийдэл юм. Үүний үр дүнд зарын тоо хөөцөлдөхөөс зайлсхийж, үнэ нь өсөхийн зэрэгцээ зорилтот бүлэгт хүрэх боломж сайжирна.

Tencent түүнчлэн өнгөрсөн онд мобайл төлбөрийн үйлчилгээг идэвхтэй хэрэглэгчдийн тоог 600 саяд хүргэж, хоёр дахин нэмэгдүүлсэн ба мөн хугацаанд Alibaba-ийн төлбөрийн хэрэгсэл болох Ant Financial-ийн хэрэглэгчдийг бас хоёр дахин өсгөсөн авч 450 саяас даваагүй аж. Бээжинд байрладаг Marbridge Consulting-ийн шинжээч Марк Наткин "WeChat Pay Alipay-ийн ард явж байсан боловч одоо байдал эсрэгээр эргэж, Alipay өрсөлдөгчөө дуурайн нийгмийн сүлжээний онцлогийг тусгасан үйлчилгээнүүд санал болгохыг оролдож байна" гэсэн юм.

Tencent Хятадын төв банктай хамтран онлайн төлбөрүүдийг боловсруулах төлбөрийн төв платформ бий болгохоор ажиллаж байна. Энэ нь онлайн төлбөрийн үйл ажиллагаанд илүү зохицуулалт хийгдэх дохио юм. Jefferies хөрөнгө оруулалтын банкны интернэт судалгааны хэлтсийн тэргүүн Жесси Гуо "Tencent-эд хандах зах зээлийн хүлээлт улам дээшилж байна. Ялангуяа, мобайл тоглоомын гүйцэтгэл дээшлэх байх гэсэн хүлээлт хамгийн өндөр байгаа" гэв. Sensor Tower хэмээх судалгааны фирмийн ажилтан Руика Линий ярьснаар өнгөрөгч улиралд Honor of Kings нэртэй тоглоом дэлхийд мобайлаар хамгийн олон татагдсан тоглоомоор шалгарчээ.

Энэхүү тайлан гарахын өмнөх өдөр тус компани Universal Music-тэй Хятадад хөгжмийн бичлэг түгээх гэрээ байгуулсан юм. Ингэснээр Tencent Music өрнөдийн хөгжмийн гол гурван брэндтэй түншлэгч болсон байна. Ноён Наткин цааш нь ярихдаа "Tencent бизнесээ төрөлжүүлэх чиглэлд маш сайн ажиллаж байгаа. Гуравдугаар сард Alibaba шинэ зах зээлийн хамгийн үнэ цэнэтэй хувьцаа хэмээх цолыг хүртсэн бол Tencent-ийн хувьцааны үнэ хэлбэрэлтгүй өсөж, хөрөнгө биржийн үнэлгээ нь 320 тэрбус ам.долларт хүрээд байгаа"-г онцоллоо.

FT

Ногоон хувьсгал Африкийн боломжийг нээнэ

Дэвид Пиллинг

Тус тив жилдээ 40 тэрбум ам.долларын хүнс импортолдог авч хөдөө аж ахуйн том үйлдвэрлэгч болох боломж бий. Беатрис Нката "Сорго бол мөнгө" гэж хэлэх дуртай. Түүний дэлгүүр гэгдэх сарайсан модон амбаарт шалнаас нь дээвэрт тултал үр, бордоо, хортон устгагч хураажээ. Хаалганы жижиг цонхоор худалдан авагчдад үйлчилнэ. Кенийн нийслэл Найробигээс зүүн хойш 260 километрт оршдог Мукотима гэдэг нойрмог хотын энэхүү зай муутай пинг дэлгүүр гэхэд хэцүү. Гэвч энэ газар Африкийн мянга мянган фермерийн амьдралыг өөрчлөхөд тусалж байна. Хатагтай Нкатаг ирэхээс өмнө нутгийн иргэд зах зээлгүйн улмаас цөөн шуудай шош, эрдэнэ шиш мэтийг зарж, амь зогоодог байжээ.

Ойрын хотод хүрэхийн тулд энхэл донхол замаар 90 минут явах хэрэгтэй. Фермерүүд зам дээр зогсож, тарьсан зүйлээ худалдахыг оролдовч олигтой ахицгүй. 38 настай бизнес эмэгтэй Беатрис Нката Соргоны анхдагчийн агентлагийг үүсгэн байгуулснаар байдал өөрчлөгдсөн гэдэг. Тэрбээр Зүүн Африкийн нэрэх үйлдвэрүүдийн ганц нийлүүлэгч болсны дотор Diageo компанийн эзэмшдэг Найроби дэх үйлдвэр ч багтана. Тэд хямд үнэтэй шар айраг үйлдвэрлэхийн тулд соргыг ихээр худалдан авдаг. Энэ нь түүний 14000 фермерт баталгаатай орлого гэсэн үг. Тэд түүнчлэн алга дарам газар дээрээ соргыг тариалах арга барилыг судалж, ургацаа арвижуулахыг эрмэлзэж байна.

Хатагтай Нката тэдэнд үр, бордоог голдуу зээлээр худалдахын зэрэгцээ трактор, үр цацагч зэргийг түрээслүүлнэ. Сургалтын төлбөрийн урьдчилгааг ч зээлээр төлж байсан удаа бий. Түүний фермерүүдийн нэг 61 настай Жафет Кибаарагийн хувьд амьдрал нь одоо л эхэлж байгаа аж. Тэрбээр "Би ядуу байдалдаа бүүр дасчихсан байсан" гээд инээснээ үхэр, ямаатай худалдан авч, эхнэр нь мөнгөний ачаар сайхан хувцасладаг болсныг ярив. Түүний найман хүүхэд ажил хийх буюу сурч байгаа гэнэ. Африк бол маш түргэн хотжиж байгаа тив. Гэвч хүн амынх нь 60 орчим хувь хөдөөд амьдардаг агаад зарим нь хэдэн зууны өмнөх аргаараа тариалан эрхэлдэг. Ургац сайжирсан хэдий ч хөгжил дэвшлийн ард хоцорчээ.

Африк тив хөдөө аж хуйн том үйлдвэрлэгч болох чадалтай. Гэтэл 40 тэрбум ам.доллараар хүнс импортолж байна. Сомали, Өмнөд Судан, Нигери зэрэг оронд өлсгөлөн нүүрлээд байгаа үед мөнгө олох тариалан, хүнсний экспортын тухай ярих нь мэдрэмжгүй мэт санагдаж магадгүй. Гэхдээ Африкийн өлсгөлөн муу цаг агаар, муу ургацаас бус муу бодлогоос улбаатай. Юуны өмнө африкчууд тариалангийн бизнесийн талаар бодох цаг болж. Зөв бодлого хэрэгжүүлбэл тус тив хүнс экспортлогч болж чадна. Үүнээс олон талын ашиг тус ирнэ. Газар дээр амьдарч буй хагас тэрбум хүний амьжиргааг дээшлүүлэхээс гадна гэр бүлийн хэмжээгээ багасгаж, дараа үеэс амьдралын түвшнээ эрс өсгөх боломж нээж болох юм.

Макро эдийн засгийн үүднээс авч үзвэл хүнс экспортлогчид гадаад валютын нөөц арвижуулж, Тайвань, Өмнөд Солонгост бүтээмжийн гайхамшгийг бий болгосон капиталын хуримтлал үүсгэх боломжтой. Үүнд цөөхөн зүйл шаардлагатай гэж Руандын Хөдөө аж ахуйн сайд асан, одоо Найробид ТББ ажиллуулж байгаа хатагтай Агнес Калибата ярилаа. Тухайлбал, фермерүүд итгэлтэйгээр тариалахын тулд газар ашиглалтын журам тодорхой байх, бүс нутгийг үрээр илүү хангах, тариалагчид илүүдлээ зах зээлд хүргэхийн тулд орон нутгийн уялдааг сайжруулах, усалгааны систем барих зэргийг дурдав. Хатагтай Калибатагийн хэлснээр юуны өмнө Засгийн газрууд фермерийн аж ахуйд анхааралтай хандаж, дэмжих ёстой бол хувийнхан хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй аж.

Тэрбээр Африкийн олон удирдагч хөдөө аж ахуйг хоцрогдсон бөгөөд хөгжлийг урагшуулах салбар биш гэж үздэгийг дурдав. Хэрэв өрнөдийнхөн туслахыг хүсэж байгаа бол тэд ядуу фермерүүдэд ямаа худалдан авч өгөх буюу шоколад худалдан авахдаа таван хувийг илүү төлөх хэрэгтэй юм. Тариалангийн татаас олгож, Африкийн фермерүүдэд дэлхийн зах зээлд өрсөлдөх замыг нээж өгөх шаардлагатай. Африкийн удирдагчид технологийн ачаар газарт хүрэлгүй ядуурлаас гарна гэдэг мөрөөдлөөсөө салах ёстой. Тэд их үсрэлт буюу технологийн дөрөвдүгээр хувьсгал мэтийн ярихаас татгалзаж, ханцуйгаа шамлан тариалангийн гутлаа өмсөөд жинхэнэ хувьсгал буюу ногоон хувьсгалын тухай ярих нь өгөөжтэй.

FT

Эдийн засаг

ТӨСӨВ

Эрүүлжиж эхэлсэн улсын төсөв

Энэ онд орлогын өсөлт эрчимжиж, зарлагынх саарчээ

С.Батсайхан/ ЗГМ©

◀1

Монгол Улсын төсвийн зарлага бараг таван жил дараалан тэлж байна. Одоогоос долоон жилийн өмнө ОУВС Монголд "Стэнд бай" хөтөлбөр хэрэгжүүлж дуусан тэр цагаас хойш манай төсвийн зарлага тасралтгүй нэмэгджээ. 2009 оны дөрөвдүгээр сард Монгол Улсын Засгийн газар 153 сая ам.долларын санхүүжилттэй "Стэнд бай" хөтөлбөр хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд буюу Валютын сантай дотно "нөхөрлөсөн" хоёр жилийн төсөв төдийлэн тэлээгүй байдаг.

Харин хоёр талын хамтын ажиллагаа дуусгавар болж, ОУВС-гийн хараанаас мултарсан 2011 оноос Засгийн газрын зарлага хоёр их наяд төгрөгөөр тэлэв. Тодруулбал, гурван их наядаас таван их наяд орчим төгрөг болтол нь өсгөжээ. Үүнээс хойш төсөв тооцоогүй томорч, орлогын өсөлт саарч, зарлага нь дээшилсээр байв. Ингэснээр төсвийн орлого, зарлагын дэнс тэнцэхээ болж, алдагдлын хэмжээ талийсаар таван жилийг үджээ.

Төсвийн орлого ойролцоогоор 500 тэрбум төгрөгөөр өсчээ

Тэгвэл энэ онд эсрэгээрээ орлогын өсөлт эрчимжиж, зарлагынх саарчээ. 2017 оны дөрөвдүгээр сарын байдлаар улсын төсвийн зарлага жилийн өмнөхөөс 60 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол орлого ойролцоогоор 500 тэрбум төгрөгөөр өссөн байх юм. Орлого тэлж, зарлага саарснаас төсөв эрүүлжиж, алдагдал буурчээ. 2016 оны дөрөвдүгээр сартай харьцуулахад төсвийн алдагдал бараг хоёр дахин буурчихаад байна. Жилийн өмнө хэдийнэ хагас их наядыг давж байсан сангийн алдагдал өдгөө 285 тэрбум төгрөгт хүрсэн. Өөрөөр хэлбэл, алдагдал ойролцоогоор 380 тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд орлогын өсөлт зарлагынхаас 23.8 пунктээр илүү байсан нь нөлөөлсөн байна.

Одоо ганц асуулт. Орлого яагаад ийн өсөв. Сангийн яамны мэдээлэлд дурдсанаар орлогын албан татвар хамгийн өндөр буюу 260-аад тэрбум төгрөгөөр өсчээ. Дээрээс нь нэмэгдсэн өртгийн албан татвар 107 тэрбум төгрөгөөр өсөж, бусад төрлийн татвар, төлбөр хураамжийн орлого 50 тэрбум төгрөгөөр дээшилжээ. Энэ нь манай төрийн санг тэтгэсэн байна.

Үүнээс гадна өсөлт дагуулсан нэгэн түүхий эд Монголын эдийн засагт ногоон гэрэл асаагаад хэдэн сарын нүүр үзэж байна. Энэ бол нүүрс. Нүүрсний экспорт биет дүнгээрээ 2.3 дахин өссөн. Эхний дөрвөн сард Монгол Улс нийт 11.6 сая тонн нүүрс экспортолсон нь жилийн өмнөх 5.05 сая тоннтой харьцуулахад хоёр нугалсан дүн. Харин мөнгөн дүнгээр бараг тав дахин өссөн байх юм. Монголчууд 2016 оны дөрөвдүгээр сард 155.8 сая ам.долларын нүүрс экспортолж байсан бол өдгөө 769.8 сая ам.доллар олжээ. Өөрөөр хэлбэл, нэг их наяд төгрөгөөр дээшилсэн гэсэн үг.

Тэгвэл төсвийн зарлагын тухайд төдийлэн өсөөгүй, өнгөрсөн оны түвшинд хадгалагджээ. Төсвийн зарлагын 88.1 хувийг урсгал зардал бүрдүүлсэн. Харин 9.7 хувийг хөрөнгийн зардал, 2.2 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна. Хөрөнгийн зардлын төсөвт эзлэх жин 4.5 пунктээр буурсан бол урсгал зардлынх 3.3, цэвэр зээлийнх 1.2 пунктээр тус тус өсчээ. Гэхдээ Засгийн газрын өр үлэмж хэмжээгээр нэмэгдээд байна. Өнгөрсөн оны мөн үед зээлийн хүүгийн төлбөрт Засгийн газар 120-иод тэрбум төгрөг төлж байсан бол одоо 330 тэрбум төгрөгт хүрчээ.

Эцэст нь, төсвийг тэтгэх "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-өөс урьдаад манай улсын санд эерэг шинж ажиглагдаад байна. Энэ жишгээр төсвийн сахилга батыг сахиж чадвал улсын төсөв эрүүлжих боломж бүрдэнэ. [ЗГМ]

Хөрөнгийн зардлын төсөвт эзлэх жин 4.5 пунктээр буурсан



ХУДАЛДАА

Жижиглэн худалдааны орлого өсчээ

Ж.Жаргалмаа
Шинжээч

Жижиглэн худалдааны орлого энэ оны эхний улиралд 2016 оны мөн үеэтэй харьцуулахад 28 хувиар өсчээ. Мөн бөөний худалдааны орлого таван хувиар өссөнийг Үндэсний статистикийн хорооноос мэдээллээ. Худалдаа эрхлэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 18 хувиар нэмэгдсэн байна. Орос, Монголын иргэд харилцан визгүй зорчих болсон нь үүнд нөлөөлжээ. Он гарснаас хойш ОХУ-ыг зорьсон иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн байна. Хойд хөршийг зорих иргэдийн дийлэнх нь худалдаа эрхлэгчид байдаг гэж аялал жуулчлалын судалгааны газруудын онцолсон юм. Түүнчлэн орос бараа Монголын зах зээлд өргөн нэвтрэхийн хэрээр БНХАУ-ыг зорих урсгал татарчээ. Энэ он гарснаас хойш урд хөршийг зорих иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар буурсан аж. Үүнээс гадна 21 аймгийн худалдааны орлого оны нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 29 хувиар өсчээ. Тэр дундаа Өмнөговь аймгийн худалдааны орлого өмнөх оны мөн үеэс 50 хувиар нэмэгдсэн нь хамгийн өндөр дүн болж байна. Тус аймгийн уул уурхайн олборлолт нь өмнөх оны мөн үеэс 300 орчим хувиар нэмэгджээ. Мөн тус аймгийн хэмжээнд худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн тоо 20-иор нэмэгдэж, ажилгүй иргэдийн тоо 8.2 хувиар буурсан аж.

УУЛ УУРХАЙ

Гацууртын хэлэлцээ үргэлжилнэ

Н.Алтан
Шинжээч

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Centerra Gold" компани Монгол Улсын Засгийн газартай "Гацуурт" төслийн хэлэлцээрээ үргэлжлүүлэхээ мэдэгдлээ. Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах болон бусад яриа хэлэлцээр 2016 оноос эхэлсэн ч одоо хүртэл үргэлжилж байгаа юм. Үүнээс гадна хэрэв Гацуурт төслийн яриа хэлэлцээ удааширч, амжилтгүй болбол хөрөнгө оруулалтын үнэлгээ 48 сая ам.долларaар буурах тооцоо гарчээ. Тус компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг харвал 2017 оны нэгдүгээр улиралд 285 сая 342 мянган ам.долларын борлуулалтын орлого олсон байна. Үүнээс дийлэнх хэсэг буюу 220 сая 266 мянган ам.долларыг алтны борлуулалтаас олжээ. Харин үлдсэн хэсгийг зэс, молибден зэрэг бусад түүхий эд эзэлж байна. Тус компанийн уул уурхайн үйл ажиллагааны ашиг 107.9 сая ам.доллар байсан байна. Харин цэвэр ашиг 56.9 сая ам.доллар байгаа нь 2016 оны мөн үеэс бараг 39 сая ам.долларaар нэмэгджээ.

ОРЛОГО

"Эрдэнэс Тавантолгой" 80 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ

Т.Элиса
Шинжээч

"Эрдэнэс Тавантолгой" компани энэ оны нэгдүгээр улиралд 80 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Тус компани улсын төсөвт 40 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн талаар гүйцэтгэх захирал Д.Ариунболд УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд мэдээллээ. Түүнчлэн Улаанбаатарт ирээд байгаа "Chalco" компанийн төлөөлөлтэй уулзаж, зүүн Цанхийн нүүрсийг цаашид ямар үнээр нийлүүлэх талаар ойрын хугацаанд хэлэлцээр хийхээр төлөвлөж байгааг онцоллоо.

Он гарсаар "Эрдэнэс Тавантолгой" компани баруун Цанхийн 300 мянган тонн нүүрсийг тонн тутмыг нь 71.5 ам.долларaар борлуулсан. Мөн дахин 100 мянган тонн нүүрсийг тонныг нь 72.8 ам.долларaар борлуулах тендер зарлаж, тавдугаар сарын 16-нд холбогдох баримт бичгийг хүлээн авч дуусан байна. Тус компани өнгөрсөн дөрвөн сард зүүн Цанхийн уурхайгаас олборлосон нүүрсийг тонныг нь 59.3 ам.долларaар "Chalco"-д нийлүүлжээ.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд дурдсанаар "Эрдэнэс Тавантолгой" компанийн үнэлгээ ойролцоогоор дөрвөн тэрбум гаруй ам.доллар буюу 11.4 их наяд төгрөгт хүрнэ гэдгийг тус компанийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд дуулгажээ. Гэхдээ зөвхөн "Эрдэнэс Тавантолгой" төдийгүй "Эрдэнэс Монгол" компанийн үнэлгээг тогтоохоор олон улсад сонгон шалгаруулалт зарласан байна. 2017 оны эцсээр үнэлгээг нь хийж дуусна гэсэн хүлээлттэй байгааг "Эрдэнэс Монгол" компанийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт мэдээллээ.

Харин одоогоор "Оюутолгой" төслийн 34 хувийг эзэмшигч Монгол Улсын Засгийн газрын өрийн хэмжээ нэг тэрбум ам.доллар байгаа гэдгийг "Эрдэнэс Оюутолгой" компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбаатар онцолж байна. "Оюутолгой"-н гүний уурхайн бүтээн байгуулалт дуусаж, бүтээгдэхүүний гарц жигдэрсний дараа 2023 он гэхэд хамгийн өндөр бүтээмжтэйг ажиллаж эхлэх тооцоотой байгаа аж.

Монгол Улсын Засгийн газар 2032 оноос ногдол ашгаа хүртэж эхэлнэ. Гэхдээ бидэнд өр зээл байгаа учраас ногдол ашгаа буцааж төлөх санхүүгийн загвар байгаа гэдгийг "Эрдэнэс Оюутолгой" компаниас тодотголоо.

ЗГМ ТОВЧХОН

» ТЭЭВЭР

1.5

Хувь. Агаарын тээврээр өнгөрсөн дөрвөн сард нийт 875.6 тонн ачаа, давхардсан тоогоор 202.5 мянган хүн тээвэрлэжээ. Өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 1.5, зорчигчид 17.5 хувиар өссөн дүн аж.

» АМЬЖИРГАА

25

Мянган төгрөг. Өрхийн дундаж зарлага өнгөрсөн улиралд 25 мянган төгрөгөөр хумигдаж, 940 мянган төгрөгт хүрсэн байна. Ийн багасахад хүнсний бус бараа, үйлчилгээ болон бусад зарлага 34.1 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

» ТЭТГЭМЖ

50.9

Тэрбум төгрөг. Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар 18 хүртэлх насны 639.1 мянган хүүхдэд 50.9 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж олгожээ.

» ТӨЛӨВ

6

Хувь. Нүүрсний ханш 2017 онд зургаан хувиар өснө гэж Дэлхийн банк таамаглажээ.

» ҮНЭТ ЦААС

14

Хувь. Төв банкны нэг долоо хоногтой 309 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 14 хувийн хүүтэй арилжлаа. Ингэснээр энэ сарын 17-ны байдлаар төв банкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 1251.4 тэрбум төгрөгтэй тэнцэв.

» ТҮҮХИЙ ЭД

0.5

Хувь. Алтны ханш олон улсын зах зээлд 0.5 хувиар суларч, 1254.56 ам.доллартай тэнцлээ.

0.4

Хувь. WTI төрлийн газрын тосны ханш 0.4 хувиар суларч, 48.89 ам.долларт хүрчээ. Тус түүхий эд өнгөрсөн лхагва гарагт 0.8 хувиар өссөн юм.

» ХӨДӨӨ АЖ АХУЙ

8

Хувь. Энэ долоо хоногийн байдлаар улсын хэмжээнд хаврын тариалалтын явц найман хувьтай байгааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мэдээллээ.

» ДЭЛХИЙД

1.7

Хувь. Японы ДНБ нэгдүгээр улиралд 1.7 хувиар өссөн байна. Иенийн ханш суларснаар тус улсын экспорт 0.1 хувиар нэмэгджээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2418.32
Евро	2692.19
Япон иен	21.81
ОХУ рубль	42.02
БНХАУ юань	350.83
БНСУ вон	2.15

Эдийн засаг

ДЭЛХИЙД

ОХУ-ын эдийн засаг 0.5 хувиар өсөв

Удаан хугацаанд үргэлжилсэн хямралаасаа гарсан ОХУ-ын эдийн засаг энэ оны нэгдүгээр улиралд 0.5 хувиар өсчээ. Энэ нь “Bloomberg”-ийн шинжээчдийн 0.4 хувийн таамгаас давсан үзүүлэлт аж. Тус улсын ДНБ өнгөрсөн оны сүүлийн улиралд 0.3 хувиар өсөж байжээ. ОХУ-ын Сангийн яамны мэдээлснээр Уралын газрын тосны ханш өнгөрсөн улиралд өмнөх оны мөн үеэс 63 хувиар өссөн байна.

Тус улсын эдийн засаг түүхий эдийн уналтын үед болон газрын тосны ханш эргээд огцом өсөх үеийн цочролыг тэсвэрлэж, өсөлтөө хадгалах чадвартай байна гэж шинжээчид дүгнэжээ. 2016 онд түүхий эдийн зах зээл унах үед ОХУ-ын эдийн засаг 0.2 хувиар агшиж байсан. Харин энэ онд 1.5 хувиар өсөх таамагтай байна. Үүнд газрын тосны ханш тогтворжихтой зэрэгцээд иргэдийн хэрэглээний зарцуулалт өсөх нь дэмжлэг болно гэж шинжээчид тайлбарласан байна. Тус улсын Засгийн газраас газрын тосны гарцаа үргэлжлүүлэн танахад бэлэн гэдгээ мэдэгдсэн. Мөн танах хэмжээгээ ч өргөжүүлэхийг OPEC-ийн гишүүн болон гишүүн бус орнуудад хандан илэрхийлээд байгаа юм. [ЗГМ]

"MSE ALL" индекс 845.05 нэгжид хүрэв



Монголын хөрөнгийн зах зээлийн MSE ALL индекс сүүлийн нэг сард (нэгжээр)

Монголын хөрөнгийн зах зээлийн "MSE ALL" индекс 845.05 нэгж болж, 0.13 хувиар өслөө. Пүрэв гарагт I, II, III ангилалд бүртгэлтэй 25 хувьцаат компанийн 75,918 ширхэг хувьцаа арилжсанаас 15 компанийн хувьцааны ханш өсчээ.

Харин есөн компанийн хувьцааны ханш буурч, нэг хувьцааны ханш тогтвортой байсан аж. Үүнээс “Нэхээсгүй эдлэл" компанийн хувьцааны ханш хамгийн өндөр буюу 14.9 хувиар өссөн бол "Агротехимпекс” компанийн ханш 12 хувиар буурсан нь огцом уналтад тооцогдож байна.

Түүнчлэн Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 932 ширхэг үнэт цаас 87 сая төгрөгөөр арилжжээ. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	61.62	▲ +2.22%	5/18/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.037	▼ -5.13%	5/17/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	22.125	▼ -1.12%	5/17/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.019	▼ -5%	5/17/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	5/17/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.08	▲ +1.99%	5/18/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.66	▼ -3.68%	5/18/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.395	▲ +25.4%	5/17/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.21	▲ +2.44%	5/17/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.52	▼ +1.96%	5/18/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ ($)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1259.8	▼ -0.12%	5/18/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	946.2	▲ +0.01%	5/18/2017
МӨНГӨ	SIA	унци	16.905	▼ -0.01%	5/18/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	253.9	▼ -0.29%	5/18/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	62.04	▲ +0.46%	5/17/2017
WTI ТОС	CLA	баррель	49.08	▲ +0.02%	5/18/2017
БРЕНТ	COA	баррель	52.05	▲ +0.77%	5/18/2017
БЕНЗИН	XBA		160.55	▲ +0.17%	5/18/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.209	▲ +0.53%	5/18/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	5/17/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	74.1	▲ +0.76%	5/18/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.163	▲ +2.77%	5/18/2017
БУДАА	RRA	центнер	10.91	▲ +2.49%	5/18/2017
БУУДАЙ	WA	бушель	427	▲ +0.65%	5/18/2017
КАКАО	CCA	тонн	2054	▲ +1.38%	5/18/2017
КОФЕ	KCA	фунт	1.344	▲ +2.43%	5/18/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	320.97	▼ -1.24%	5/17/2017
ГОВЬ ХК	GOV	13870	▲ -3.61%	5/17/2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	11000	▲ 4.76%	5/17/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20500	◀▶ 0%	5/17/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2300	▼ -0.22%	5/17/2017
БАГАНУУР ХК	BAN	1890	▼ -3.42%	5/17/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	125	◀▶ 0%	5/17/2017
ЖЕНКО ТУР БЮРО ХК	JTB	50.42	▼ -6.63%	5/17/2017
РЕМИКОН ХК	RMC	46	◀▶ 0%	5/17/2017
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2250	▲ 1.35%	5/17/2017
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	4750	▼ -2.18%	5/17/2017
МОНГОЛ КЕРАМИК ХК	KEK	9000	▼ -10%	5/17/2017
ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ХК	SUN	48.89	▲ 14.98%	5/17/2017
ТЭЭВЭР ДАРХАН ХК	TEE	13000	▼ -7.14%	5/17/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6011.234	-158.64	▼ -2.57%	5/18/2017
DAX INDEX	DAX	12631.61	-172.92	▼ -1.35%	5/17/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15273.68	-269.65	▼ -1.73%	5/18/2017
S&P/ASX 200	AS51	5756.301	-29.73	▼ -0.51%	5/18/2017
S&P 500	INX	2357.03	-43.64	▼ -1.82%	5/18/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3104.442	-8.52	▼ -0.27%	5/17/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20606.93	-372.82	▼ -1.78%	5/18/2017
TOP 20	MSETOP	12973.88	+32.87	▲ +0.25%	5/17/2017
FTSE 100	UKX	7503.47	-18.56	▼ -0.25%	5/18/2017
HANG SENG	HSI	25293.63	-42.31	▼ -0.17%	5/17/2017
NIKKEI 225	NKY	19814.88	-104.94	▼ -0.53%	5/17/2017